



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 22

Улсанбаатар хот

"Ногоон дүүрэг" хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Байгальд ээлтэй эко санал, санаачилгыг нэвтрүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, агаар, хөрсний бохирдлыг багасгах, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх замаар иргэд, олон нийтэд экологийн боловсролыг төлөвшүүлж ногоон хөгжлийг дэмжих зорилго бүхий "Ногоон дүүрэг" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга Л.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1158100677
© 2017, Togtool



“НОГООН ДҮҮРЭГ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал

1.1 Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2 дахь заалт “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Байгаль хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт “Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ” Ойн тухай хуулийн 28.1.2.3 дахь заалт, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль, Хог хаягдлын тухай 1.1, 3.1.8, 7.3, 16.1, 24,1.2, дахь заалт, Усны тухай хууль 4 дүгээр бүлэг, 31 дүгээр зүйл, 1,2,3 дугаар заалт, 3 дугаар бүлгийн 22 дугаар заалт, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дүгээр заалт, 411 дүгээр зүйлийн 2.3, 56,63, 56.7 дахь заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 11.4, 12.5, 12.6.3, 13.1.4, 14.4 дахь заалтуудыг үндэслэн нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Засаг даргын 2017 оны А/01 тоот захирамжаар 2017 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх, тухайн оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг баримтлан ажиллана.

1.2 Улаанбаатар хотын хүн ам 1.3 сая-д хүрч, хүн амын тоо нэмэгдэхийн хирээр ногоон байгууламжийн хүрэлцээ багасч, 1970, 1980-аад онд тарьсан мод, бут сөөг хотын өнгө үзэмжийг зохих хэмжээнд хадгалж байгаа хэдий ч байгаль орчныг хамгаалах суурь хуульд байгаль орчныг хамгаалах ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын хүчээр байгаль орчныг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг явуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Өнөө үед иргэдийн мэргэжил мэдлэг дутмагаас мод бут сөөгийн хэлбэржүүлэлт, тайралт таналт, ээлжлэн тарилт /сэлгэн суулгах/ ажил технологийн дагуу хийгдээгүйгээс эмзэг болгож, амархан өвчинд өртдөг, олноороо сүйтгэгдэж байна.

Нийслэлийн хэмжээнд агаар, хөрсний доройтол, тоосжилт, бохирдолт хэмжээнээсээ хэд дахин нэмэгдэж, Улаанбаатар хотын нэг хүнд 12.3 м2 цэцэрлэгжсэн талбай ногдож байгаа нь байвал зохих дундаж хэмжээнээс 3-4 дахин бага байгаа юм. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж хүний нөлөөтэйгөөр багасч, ногоон байгууламж нэмэгдүүлэхэд талбай хомс хүн амын нягтралын дээд хэмжээнд хүрч замын түгжрэл, тоосжилт, хуурайшилт жил ирэх тутам ихэсч хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх болсон.

2014-2016 онд дүүргийн хэмжээнд “Ногоон дүүрэг” хөтөлбөр батлан хэрэгжүүлснээр 11960 ширхэг шилмүүст мод, 13029 ширхэг навчит мод, 101085 ширхэг амьд хашлага, 653 м2 цэцгийн мандал, 71970 м2 зүлэгт талбай, 104790 м2 явган хүний зам, авто зам байгуулж сул шороот хөрсийг хатуу хучилттай болгон хөрсний бохирдол, тоосонцрыг багасгаж дүүргийн хэмжээнд нэг хүнд ногдох

ногоон байгууламжийн хэмжээ 2013 оны байдлаар 0,6 хувь байсныг "Ногоон дүүрэг" хөтөлбөр хэрэгжүүлснээр нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 1,2 хувь хүргэн нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил болсон. Иймд энэхүү хөтөлбөрийг цаашид дахин хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

2.1. Байгальд ээлтэй эко санал, санаачилгыг нэвтрүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, агаар, хөрсний бохирдлыг багасгах, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 2.0-оос дээш хувьд хүргэн нэмэгдүүлэх замаар иргэд, олон нийтэд экологийн боловсролыг төлөвшүүлж ногоон хөгжлийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн зорилтууд:

3.1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр хангах төслүүдийг хэрэгжүүлж, эко бүтээгдэхүүнийг дэмжих, хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.2. Суурьшлын бүсийн агаар, хөрсний бохирдол, тоосжилтыг бууруулах зорилгоор олон талт ажил, төсөл хэрэгжүүлэх суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж, гудамж талбайг үе шаттайгаар зүлэгжүүлэх, хатуу хучилттай зам бий болгоход орчин үеийн шинэ технологиос судалж, ландшафтын өвөрмөц шийдэл бүхий ногоон байгууламж нэмэгдүүлнэ.

3.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь ногоон байгууламжийн хөгширсөн, өвчин хортонд өртсөн модыг авч нөхөн тарьж нэмэгдүүлэх, стандарт хангасан мод, бут, сөөгийг орчин үеийн шийдлээр тарьж бий болгож тэдгээрийг арчилж хамгаалахад тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагатай нь уялдуулж татан оролцуулах, урамшуулах, хороодын Иргэний танхимаар дамжуулан сургалт сурталчилгааг зохион байгуулна.

3.4. Орон сууцны хороолол дундах бичил цэцэрлэгийн хог хаягдал, ногоон байгууламжийн арчилгааг тухайн орчны Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай уялдуулан хамтарч ажиллах, сургууль, цэцэрлэгийн гадна талбайн батлагдсан "Дендроплан" ажлын зургийн дагуу үе шаттайгаар ногоон байгууламж нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагын оролцоотой сургалтад хамруулна.

3.5. Гэр хорооллын бичил цэцэрлэгийг сэргээн засварлах, шинээр томоохон гудамж талбайд бичил цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, спорт чийрэгжүүлэлтийн талбай байгуулах, дүүргийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажлын зураг төсөв, тоо хэмжээнд ногоон байгууламжийг түлхүү тусгах, хяналт тавих.

3.6. Төрийн зарим чиг үүргийн дагуу байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн нөхөрлөл, бүлгүүдийн санал санаачилга, оролцоонд тулгуурласан байгаль хамгаалах төслүүдийг урамшуулж дэмжиж ажиллана.

3.7. Чингэлтэй хайрханы бусад салбар амны орц гарцыг нээж ойжуулалт нөхөн сэргээлт хийхэд иргэд, аж ахуй нэгжийг татан оролцуулах замаар иргэдийн

бүлэг байгуулж жилдээ 1500-аас доошгүй стандартад нийцсэн модоор тарилт хийж, ургалтын хувийг дээшлүүлэн, ойн санг нэмэгдүүлж Чингэлтэй хайрхан уулаа түшиглэн аялал жуулчлалын бүс байгуулахад онцгой анхаарна.

Дөрөв. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн:

4.1. Ногоон хөгжилд тулгуурласан эко бүтээгдэхүүний хэрэглээг нэвтрүүлэх үйлдвэрлэлийг дэмжсэн, эдийн засгийн өсөлт бий болгосноор иргэдийн амьдрах нөхцөл сайжирна.

4.2. Дүүргийн хэмжээнд 14000 м²-аас доошгүй зүлэгт талбай, 118800 м²-аас доошгүй хатуу хучилттай зам бий болгосноор тоосжилтын дэгдэлт, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгаснаар, иргэдийн амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль орчны нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан, иргэд, аж ахуй нэгжийн оролцоо нэмэгдсэнээр хог хаягдал багасч, нийтийн эзэмшлийн мод бут хугарах, гэмтэх, устаж үгүй болох асуудал байхгүй болж жилд 30000 м²-аас доошгүйгээр орчин үеийн ландшафтын шийдэл бүхий ногоон байгууламж нэмэгдэнэ.

4.4. Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран гэрээ хийж ажилласнаар бичил цэцэрлэгийн, хог хаягдал, эд хөрөнгийн элэгдэл гэмтэл багасч, ногоон байгууламж сэргэнэ. Мөн төрийн болон төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн бүсийн стандарт хэрэгжиж, гаднах орчин сайжирч тоосжилт, дуу чимээ багасч эрүүл, таатай орчинд амьдрах, суралцах нөхцөл бүрдэнэ.

4.5. Гэр хороололд стандартад нийцсэн орчин үеийн загварлаг бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнг нэмэгдүүлж, гудамж талбайг орчин үеийн шийдэл загвараар тохижуулах ногоон төгөл бий болгосноор иргэдийн амрах зугаалах, бие бялдраа хөгжүүлэх чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчин бүрдэнэ.

4.6. Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн, санал санаачилга, оролцоонд тулгуурлан холбогдох төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажилласнаар байгаль орчин, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж ногоон хөгжлийн үзүүлэлт сайжирна.

4.7. Чингэлтэй хайрхан уул /Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн/ Шар хагтын амыг амралт зугаалгын бүс болгон ойжуулалт нөхөн сэргээлтийг жилд 1000-аас доошгүй стандартад нийцсэн модоор тарилт хийж, ойн санг нэмэгдүүлж ургалтыг 90 хувьд хүргэнэ. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд бүртгэлжүүлэн мэдээллийн санд оруулснаар экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх амралтын бүс бий болно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дор дурдсан эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв
- Байгаль хамгаалах сан
- Олон улсын байгууллага, хандивлагчдаас өгч буй тусламж, дэмжлэг, хандив
- Төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан Ажлын хэсэг зохион байгуулж Монгол Улсын Засгийн газрын бодлого, хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах үүрэг хүлээнэ.

6.2. Үндсэн хэрэгжүүлэгч: Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар

6.3. **Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:** Засаг даргын Тамгын газрын хэлтэс албад, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс алба, хороод, дүүргийн тохижилт, үйлчилгээний байгууллагууд, сургууль цэцэрлэгүүд, СӨХ, Төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, иргэд.

Долоо. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн явц хэрэгжилтийг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил тутам тайлагнана.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Өнөөгийн түвшин 2016 он	Зорилтот түвшин 2020 он
1. Зорилтын хүрээнд: Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр хангах төслүүдийг хэрэгжүүлж, эко бүтээгдэхүүнийг дэмжих, хэрэглээнд нэвтрүүлнэ.			
1	Эрчим хүчний хэмнэлттэй нарны зайн LED гэрэлтүүлэг	80 ширхэг	350 ширхэг
2	Цахилгаан бага зарцуулдаг халаагуурыг нэвтрүүлэх	38 өрх	10,000 өрх
3	Дулаан алдагдал багасгах өрх	0,0 өрх	1500 өрх
2. Зорилтын хүрээнд: Суурьшлын бүсийн агаар, хөрсний бохирдол, тоосжилтыг бууруулах зорилгоор олон талт ажил, төсөл хэрэгжүүлэх суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж, гудамж талбайг үе шаттайгаар зүлэгжүүлэх, хатуу хучилттай зам бий болгоход орчин үеийн шинэ технологиос судалж, ландшафтын өвөрмөц шийдэл бүхий ногоон байгууламж нэмэгдүүлнэ.			
1	Дүүргийн хэмжээнд сул шороон хөрсийг зүлэгт талбай бий болгох	157,331м2	217,331 м2
2	Дүүргийн хэмжээнд сул шороон хөрсийг Явган зам бий болгох	167,047м2	20,7047 м2
3	Дүүргийн хэмжээнд сул шороон хөрсийг авто зам бүхий хатуу хучилттай талбай бий болгох	788,190м2	988,190 м2
3. Зорилтын хүрээнд: Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь ногоон байгууламжийн хөгширсөн, өвчин хортонд өртсөн модыг авч нөхөн тарьж нэмэгдүүлэх, стандарт хангасан мод, бут, сөөгийг орчин үеийн шийдлээр тарьж бий болгож тэдгээрийг арчилж хамгаалахад тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, байгууллага аж ахуй нэгжийг үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагатай нь уялдуулж татан оролцуулах, урамшуулах,			

хороодын Иргэний танхимаар дамжуулан сургалт сурталчилгааг зохион байгуулна.

1	Ногоон байгууламжийн чиглэлээр сургалт семинарт хамруулах	80 иргэн	400 иргэнд
2	Нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага аж ахуй нэгжийг үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагатай нь уялдуулж мод, бут тарих, ногоон байгууламжийн нэмэгдүүлэх ажилд татан оролцуулах /томоохон/	200 Байгууллагууд	200 Байгууллагууд
3	Ногоон байгууламжийн хөгширсөн, өвчин хортонд өртсөн модыг авч нөхөн тарьж нэмэгдүүлэх, стандарт хангасан мод, бут, сөөгийг орчин үеийн шийдлээр тарьж ногоон байгууламж нэмэгдүүлэх.	-Шилмүүст мод 15,573 ширхэг -Навчит мод 22,529 ширхэг -Ургамлын хашлага 119,455 ширхэг	-Шилмүүст мод 20,537 ширхэг -Навчит мод 26,529 ширхэг -Ургамлын хашлага 164,455 ширхэг
4	Гадаадын орноос санаа авч орчин үеийн ландшафтын шийдэл бүхий ногоон байгууламж нэмэгдэнэ.	54 бичил цэцэрлэг	65 бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн бий болгоно

4. Зорилтын хүрээнд:

Орон сууцны хороолол дундах бичил цэцэрлэгийн хог хаягдал, ногоон байгууламжийн арчилгааг тухайн орчны Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай уялдуулан хамтарч ажиллах, сургууль, цэцэрлэгийн гадна талбайн батлагдсан "Дендроплан" ажлын зургийн дагуу үе шаттайгаар ногоон байгууламж нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагын оролцоотой сургалтад хамруулна.

1	Ногоон байгууламжийн ургалт амьдралтын хувь нэмэгдэнэ	74 хувь	96 хувь
2	Бичил цэцэрлэгийн хог хаягдал, ногоон байгууламжийн арчилгааг тухайн орчны Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай уялдуулан хамтарч ажиллах, хариуцуулах	6 СӨХ	20 СӨХ

5. Зорилтын хүрээнд:

Гэр хорооллын бичил цэцэрлэгийг сэргээн засварлах, шинээр томоохон гудамж талбайд бичил цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, спорт чийрэгжүүлэлтийн талбай байгуулах, дүүргийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажлын зураг төсөв, тоо хэмжээнд ногоон байгууламжийг түлхүү тусгах, хяналт тавих.

1	Гэр хорооллын бичил цэцэрлэгийг сэргээн засварлах, шинээр томоохон гудамж талбайд бичил цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, спорт чийрэгжүүлэлтийн талбай байгуулах арчилгаа хамгаалалтыг тогтмол хийх	25 Бичил цэцэрлэг	30 Бичил цэцэрлэг
2	Дүүргийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажлын зураг төсөв, тоо хэмжээнд ногоон байгууламжийг түлхүү тусгах, хяналт тавих.	Тухайн зураг төслийн 10 % нь ногоон байгууламж байна.	Тендерт шалгарсан компанийн ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих 30 % нь ногоон

			байгууламж байлгах, хүлээн авах комисст орж тоо хэмжээгээр нь хүлээн авна.
6. Зорилтын хүрээнд:			
Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн, санал санаачилга, оролцоонд тулгуурлан холбогдох төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажилласнаар байгаль орчин, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж ногоон хөгжлийн үзүүлэлт сайжирна.			
1	Шар хагтын амны нөхөн сэргээлт ойжуулалтын ажил дэмжсэн хэрэгжүүлж байна.	Одоогийн байдлаар 30 хувьтай төсөл хөтөлбөр хэрэгжин үе шаттайгаар явагдаж байна	Шар хагтын амын нөхөн сэргээлт ойжуулалтын ажил бүрэн 100 хувь дууссан.
7. Зорилтын хүрээнд:			
Чингэлтэй хайрхан уул /Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн/ Шар хагтын амыг амралт зугаалгын бүс болгон ойжуулалт нөхөн сэргээлтийг жилд 1000-аас доошгүй стандартад нийцсэн модоор тарилт хийж, ойн санг нэмэгдүүлж ургалтыг 90 хувьд хүргэнэ. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд бүртгэлжүүлэн мэдээллийн санд оруулснаар экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх амралтын бүс бий болно.			
1	Чингэлтэй хайрхан уул /Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн/ Шар хагтын амыг амралт зугаалгын бүс болгон ойжуулалт нөхөн сэргээлтийг жилд 1000-аас доошгүй стандартад нийцсэн модоор тарилт хийж, ойн санг нэмэгдүүлж ургалтыг 90 хувьд хүргэнэ	13,140 ширхэг мод бут тарьсан үүнээс 7853 ургаж байна 68,7 хувьтай ургаж байна.	17,140 ширхэг ургалтыг 90 хувьд хүргэнэ



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

"Чингэлтэйд үйлдвэрлэв" хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жижиг дунд болон өрхийн үйлдвэр эрхлэгч иргэдийг дэмжин үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох экспортыг нэмэгдүүлэх шинэ технологи бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох, эдийн засагт жижиг дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго бүхий "Чингэлтэйд үйлдвэрлэв" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



1150100075
D:\2017\ Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт



“ЧИНГЭЛТЭЙД ҮЙЛДВЭРЛЭВ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал

Дүүргийн хэмжээнд 2016 оны байдлаар оёдол 282, гутал үйлдвэрлэл 82, арьсан эдлэл 33, модонд эдлэл сийлбэр 121, сүлжмэл ноосон эдлэл 84, эсгийн урлал 42, гар урлал бэлэг дурсгал 55, төмөр хийцийн үйлдвэрлэл 33 бусад чиглэлээр 39 нийт 771 өрхийн үйлдвэрлэгч болон аж ахуй нэгжийн бүртгэл судалгаа байна.

2014-2016 онд хэрэгжүүлсэн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжиж 1000 гаруй иргэн аж ахуй нэгжид 2.4 тэр бум төгрөгийн төсөл хөтөлбөр, зээл санхүүгийн дэмжлэгт хамруулж 377 ажлын байрыг хадгалж, 269 ажлын байрыг шинээр нэмэгдүүлсэн байна. Хөнгөлөлттэй зөөврийн ажлын байрны төсөлд 30 өрхийн үйлдвэрлэгчийг хамруулан шинээр 70 гаруй ажлын байр нэмэгдүүлээд байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор төвийн инкубацын үйлчилгээнд давхардсан тоогоор 1644 иргэн хамрагдсан.

2015 онд “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвүүдийг нээн ажиллуулж 125 иргэн хамрагдаж 131,6 сая төгрөгийн борлуулалт хийсэн бол 2016 онд 211 иргэн хамрагдаж 237,1 сая төгрөгийн борлуулалт хийж өмнөх оноос 80,5 хувиар өссөн байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр борлуулалтыг жил бүр 30-аас багагүй хувиар, хамрагдах иргэдийн тоог мөн жил бүр 15-аас багагүй хувиар тус тус нэмэгдүүлнэ.

Монгол Улсын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр бодлого гарч жижиг дунд үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж буй энэ цаг үед монгол хүн бүрийг үндэсний үйлдвэрлэлээ дэмжих сэтгэлгээг төлөвшүүлэх нь чухал байна.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.49 дүгээр зүйлд Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо худалдаа үйлчилгээний салбарын татвар эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.

Нийслэл дүүргийн Засаг даргын 2016-2020 мөрийн хөтөлбөр, 2017 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бүхий инновацийн тогтолцоог дэмжих улмаар нэмүү өртөг шингэхүйц дэвшилтэд технологи, мэдлэгийг жижиг, дунд болон өрхийн үйлдвэрийн салбарт бий болгохоор ажиллаж байгаа бөгөөд дүүргийн хувьд өрхийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж үйлдвэрлэгч болгон эдийн засгийн өсөлтөд нэмэр оруулж өрхийн орлогыг нэмэгдүүлэх юм. Үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явц амжилттай явагдаж байгаа боловч бараа бүтээгдэхүүний чанар технологийг сайжруулах тухайн бүтээгдэхүүнээ олон нийтэд хүргэх, гадаад, дотоодын зах зээл

борлуулалт хийх суваг цөөн байгаа учир дээрх боломжуудыг нэмэгдүүлэх, нь “Чингэлтэйд үйлдвэрлэв” хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Жижиг дунд, болон өрхийн үйлдвэр эрхлэгч иргэдийг дэмжин үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох экспортыг нэмэгдүүлэх шинэ технологи бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү анхаарч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох, эдийн засагт жижиг дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Зорилт-1: 3.1. Нэмүү өртөг шингэсэн, бүтээмж өндөртөй, үйлдвэрлэлд суурилсан кластерын системийг хөгжүүлж жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг бүртгэлжүүлж бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах.

3.1.1. Үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүн нэр төрлийг нэмэгдүүлж, стандарт хаяг логотой болохын давуу талыг иргэд аж ахуй нэгжид сургалт сурталчилгаа хийх.

3.1.2. Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг нэгтгэн, онцлог давуу тал, шинэ технологи бүхий бүтээгдэхүүн гаргах, хамтын үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлэх.

3.1.3. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, олон улсын байгууллагуудтай оюуны багтаамжтай, өндөр бүтээмжтэй технологи нэвтрүүлэх сургалтуудыг хамтран зохион байгуулна.

3.1.4. Оюуны өмчийн үр ашигтай менежментийг нэвтрүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, нийгэм эдийн засагт гүйцэтгэж байгаа үүргийг тооцох аргачлалыг боловсруулах.

3.1.5. Үйлдвэрлэгчдийн нэгдсэн мэдээллийн бааз үүсгэж эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалд хамруулах боломжийг судлах, үйлдвэрлэгчдэд Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгалтай холбоотой сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

3.1.6. Орчин үеийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн хүний оролцоог бага хангасан техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж буй үйлдвэрүүдийг дэмжих, иргэд аж ахуй нэгжийг мэдээ мэдээллээр хангах.

Хүрэх үр дүн: Ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид чанар стандартын нэгдсэн ойлголттой болж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн оюуны өмчийн эрхээр хамгаалуулсан байна. Мэдээллийн сан бий болж иргэд сайн дурын даатгалд хамрагдаж татвар төлөгчөөр бүртгэгдэнэ.

Зорилт-2: 3.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг чадавхжуулах, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх, "Бизнес Инкубатор төв"-өөр дамжуулан сургаж бойжуулах, бизнес эрхлэх, төсөл боловсруулах, сургалт зөвлөгөө мэдээллээр хангана.

3.2.1. Жижиг, дунд үйлдвэрт зориулсан зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, бизнес эхлүүлэх, аж ахуй эрхлэх санаачилгыг идэвхжүүлэн, бойжигчдыг дэмжих.

3.2.2. Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвүүдтэй хамтран мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог сайжруулах.

3.2.3. Жил бүр "Бизнес Инкубатор төв"-өөр дамжуулан бойжигчоор чадавхжуулж өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.

3.2.4. Үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн үйлчилгээнд зуучлах, төсөл хөтөлбөр боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх.

3.2.5. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дэргэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулж "Чингэлтэйд үйлдвэрлэл"- 3 салбарын үйл ажиллагааг жигдрүүлэх /12 дугаар хороонд/

3.2.6. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин өргөжүүлж жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг болгон бойжуулах.

Хүрэх үр дүн: БИТ-ийн нэг удаад бойжих хүчин чадлын тоог жилд 30-аар нэмэгдүүлнэ. /Зөврийн ажлын байрны тоог 30-аар нэмэгдүүлнэ./ хөнгөлөлттэй ажлын байраар хангагдаж, бизнес эхлэх шинэ санаа бий болж хөдөлмөр эрхлэх анхан шатны мэдлэг мэдээлэлтэй болно.

Зорилт-3: 3.3. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж, зээл олгоход дэмжлэг үзүүлэх.

3.3.1 Шинэ технологи, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг төсөл сонгон шалгаруулах зарчмаар жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл төсөл хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.

3.3.2. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэр, бичил бизнес эрхлэгчдийг урт хугацаатай хүүгийн хөнгөлөлттэй зээлд хамруулж, зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулснаар ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

3.3.3. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийг ажлын байр, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс /лизинг/-ээр олгох үйл ажиллагааг өргөтгөх.

Хүрэх үр дүн: Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгч иргэд аж ахуй нэгж байгууллагыг зээл тусламж төсөл хөтөлбөрт хамруулснаар эргэлтийн хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, үйлдвэрлэлээ өргөтгөн, шинээр ажлын байр бий болж, эрүүл аюулгүй ажлын байранд хөдөлмөрлөх боломжоор хангагдана.

Зорилт-4: 3.4. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно.

3.4.1. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэгчдийн хамтын үйл ажиллагааг сайжруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төрөлжилт бий болгох.

3.4.2. Үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сурталчилах, туршлага солилцох зорилгоор дотоодын болон хөрш орнуудын үзэсгэлэн худалдаанд тогтмол оролцуулах, хил дамнасан болон хилийн дагуух худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүдэд өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны цэгүүд бий болгох, гуравдагч орны зах зээлд нэвтрүүлэх боломжийн талаар судлах, хамтран ажиллах түншлэл тогтоох.

3.4.3. Монгол Улсын Засгийн газрын 336 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт"-ын хэрэгжилтийг хангах, өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжин ажиллана.

3.4.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуй нэгж байгууллагуудад жижиг, дунд өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах санал санаачилгыг нэмэгдүүлэх, хэрэгцээт бараа худалдан авахад зуучлах.

3.4.5. "Чингэлтэйд үйлдвэрлэв" худалдааны төвүүдийн үйл ажиллагааны менежментийг сайжруулах замаар хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлж борлуулалтын орлогыг өсгөнө.

Хүрэх үр дүн: Үйлдвэрлэгчдийн хамтарсан багийг олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулсан байна. Төрийн байгууллагын худалдан авалт, зах зээлийн эрэлтэд тулгуурласан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болно.

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.
Хөтөлбөрийн санхүүжилт, эх үүсвэр

4.2. Хөтөлбөр тусгагдсан арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын болон /орон нутгийн төсөв/
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө
- Орон нутгийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгө
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө

- Үйлдвэрлэл, Инновацийг дэмжих сангийн хөрөнгө
- Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- Бусад эх үүсвэр

Тав. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт

5.1. Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, Худалдаа үйлчилгээний хэлтэс,
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс,
- Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих Бизнес Инкубатор төв
- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс
- Татварын хэлтэс
- Дүүргийн кластерын төв.
- Хороодын Засаг даргын ажлын алба

5.2. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим Нийслэлийн Үйлдвэр, Инновацийн газар, аж ахуйн нэгж, иргэд, олон улсын байгууллагууд.

5.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн Засаг дарга хангуулж, жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт.

6.1. Дүүргийн "Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөр"-ийн үр дүнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид хамтран шинэ технологи нэвтрүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлэн орон нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулж бараа бүтээгдэхүүний борлуулалтыг эрчимжүүлж, өрхийн орлого, шинэ ажлын байрны тоог нэмэгдүүлсэн, хадгалсан байдлаар хэмжигдэнэ.

Хөтөлбөрийн нийтлэг шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016 он	Зорилтот түвшин 2020 он	Хэрэгжүүлэх байгууллага
1	Нэгдсэн мэдээллийн сан бий болж үйл ажиллагааны чиглэл тус бүрээр тодорхойлно.	Тоо	424	700-800	ХХҮХ, БИТ
2	Үйлдвэрийн инновацид суурилсан кластерыг дагаж бий болсон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байна.	Тоо жилд	-	Жилд 3 дээш ААН иргэнийг хамруулна.	ХХҮХ Кластерын төв
3	Стандарт хаяг логотой	Хувь	15%	30%	ХХҮХ,

	болохын давуу талыг иргэд аж ахуй нэгжид хийх сургалт сурталчилгаа				БИТ
4	"Бизнес Инкубатор төв"-өөр дамжуулан бойжигчоор чадавхжуулж өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог нэмэгдүүлнэ	Тоо	19	80	БИТ
5	Дэмжлэгт хамрагдсан болон шинээр бий болсон ажлын байрны тооны өсөлт, салбар бүрээр тодорхой гарч ажлын байрны тоо нэмэгдсэн байна.	Тоо	377	500	ХХҮХ, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, БИТ
6	Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна.	Хувь	523	600	БИТ
7	Хөнгөлөлттэй зөөврийн ажлын байраар хангагдаж, бизнес эхлэх шинэ санаа бий болж хөдөлмөр эрхлэх анхан шатны мэдлэг мэдээлэлтэй болно.	Тоо	30	60	ХХҮХ, БИТ
8	Үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн үйлчилгээнд зуучлах, төсөл хөтөлбөр боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх.	Тоо	335	1200	ХХҮХ, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, БИТ
9	Үйлдвэрлэгчдийн хамтарсан багийг үзэсгэлэн худалдаануудад оролцуулсан байна.	Тоо	14 удаагийн үзэсгэлэнд 167 иргэн хамрагдсан	Жилд 15 дээш үзэсгэлэнд 200 дээш иргэн ААН-ийн хамруулна.	ХХҮХ БИТ
10	"Чингэлтэйд үйлдвэрлэв" худалдааны төвүүдийн борлуулалтыг нэмэгдүүлнэ	Хувь	211 иргэн хамрагдаж 237,1 сая төгрөгийн борлуулалт хийсэн	Жил бүр 10-15хувиар, хамрагдах иргэдийн тоог мөн жил бүр 5-10% иас багагүй хувиар тус тус нэмэгдүүлнэ	ХХҮХ БИТ

Долоо. Хяналт – үнэлгээ, үр дүнг тайлагнах явц

Хөтөлбөрийн явц хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана. Мөн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэн үнэлгээ авна.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

“Эрүүл мэнд 2020” хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орчин үеийн стандарт, шаардлага, мэдээлэл технологийн ололтод тулгуурласан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100035
D:\2017\Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт



“ЭРҮҮЛ МЭНД-2020” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл өнөөгийн байдал

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 батлах тухай” 19 дүгээр тогтоолоор “Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэх” зорилтыг хөгжлийн бусад зорилтуудын хамт дэвшүүлж, 2016-2020, 2021-2025, 2026-2030 онуудад хүрэх түвшнийг тодорхойлсон.

2030 он гэхэд нийгмийн хамгийн ядуу, эмзэг бүлгийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүрэн хамруулах зорилтуудыг биелүүлэхэд олон хүндхэн сорилт байх бөгөөд энэхүү 15 жилийн хугацаанд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан жендэрийн мэдрэмжтэй, тэгш, хүртээмжтэй тусламжид хамруулахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллах ёстой болоод байна.

Азийн Хөгжлийн Банкнаас хийсэн судалгаанаас үзэхэд хороо, өрхийн эрүүл мэндийн төвд бүртгэлтэй иргэдийн 62.2% эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чаддаг гэж хариулсан байхад бүртгэлгүй иргэдийн дөнгөж 25% тусламж үйлчилгээнд хамрагдаж чадаж байна гэжээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдийн:

- Мөнгөгүй (77.5%)
- Эрүүл мэндийн даатгалгүй (55.9%)
- Алслагдсан газар амьдардаг (31.8%) хэмээх шалтгаанууд дурджээ.

Эмзэг бүлгийн өрхүүдийн дунд хийгдсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн судалгаагаар өрх, сумын эмнэлэг, эмийн сангийн байршил, нийтийн тээврийн хэрэгслийн маршрут зэрэг нь ядуу, эмзэг бүлгийн айл өрхийн гишүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрагдалтын түвшинд нөлөөлдөг болохыг тодорхойлжээ. Иймд орон нутгийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтсүүд, Эрүүл мэндийн төв, хороо, ӨЭМТ-үүд, ижил зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТББ, ОУБ-уудтай хамтран тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй орхигдож буй зорилтот бүлгийнхний эрүүл мэнд, нийгмийн хэрэгцээнд нийцсэн, тэдэнд эрүүл мэндийн тэгш боломж олгох, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, даатгал, бүртгэл, боловсролын цогц арга хэмжээг төлөвлөх, үе шаттайгаар хэрэгжүүлэх, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

Чингэлтэй дүүрэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дүүргийн 19 хорооны 155859 хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан, хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг 16 Өрхийн эрүүл мэндийн төв, нарийн мэргэжлийн Төв салбар, Хайлааст салбар, Бага тойруу салбар, Хүүхдийн салбар нийт 4 амбулатори, хэвтэн эмчлүүлэх 227 ортой нэгдсэн эмнэлгээр дамжуулан хүргэж, Нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн

салбарын бодлого, чиглэлийг баримтлан эмнэлгийн дээд мэргэжилтэн их эмч 96, эмнэлгийн дунд мэргэжилтэн 137, бусад туслах болон үйлчилгээний ажилтан 108 нийт 341 ажилтантайгаар ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд сүүлийн 3 жилд 10000 хүн амд ноогдох өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд:

a) Амьсгалын замын эмгэг	711,54
b) Халдварт өвчин	276,37
c) Зүрх судасны өвчин	231,2
d) Мэдрэлийн тогтолцооны өвчин	188,24
e) Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин	176,21 байна.

Дүүргийн хэмжээнд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж, жилд дунджаар 4,8%-ийн өсөлттэй байна. 2016 оны жилийн эцсээр жирэмсний эрт хяналт 85,7%-тай, эхийн эндэгдэл 1 тохиолдол буюу 100 000 төрөлтөнд 23,08 бүртгэгдсэн нь нийслэлийн дунджаас 15,8, улсын дунджаас 18,0-оор бага үзүүлэлттэй юм. 2016 онд 4174 эх амаржиж 4209 нярай мэндэлсний 99,8%-ийг эрүүл мэндийн мэргэжилтэн эх барьж төрүүлсэн бол гэрийн төрөлт 10 буюу 0,2%, төрсөн эхчүүдийн 22,4% нь эрхтэн тогтолцооны эмгэгтэй байсан.

Амьгүй төрөлт 24 тохиолдол буюу 5,7 промилль байгаа нь өмнөх оны мөн үетэй харилцуулахад 1,11-оор буурсан бөгөөд нийслэл, улсын дунджаас доогуур түвшинд, хяналтгүй төрөлт 24 буюу 0,6% байгаа нь 0,14%-иар буурсан хэдий ч нийслэл, улсын дунджаас их үзүүлэлттэй байна. 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 50 тохиолдол буюу 1000 амьд төрөлтөд 11,9 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,34-аар өссөн, нийслэл, улсын дунджаас доогуур үзүүлэлт байна.

1000 амьд төрөлтөнд ноогдох 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 11 тохиолдол буюу 2,6 промилль бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,75 промилиор өссөн ч нийслэлийн дунджаас 0,08 промилиор, улсын дунджаас 0,6 промилиор бага байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13,4%-ийг гадны шалтгаантай осол гэмтэл эзэлж байна.

Халдварт өвчний 4213 тохиолдол бүртгэгдсэн нь 10 000 хүн амд 268,06 ноогдож, бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэ, салхин цэцэг, гэдэсний замын халдварт өвчнүүд тэргүүлэх байрыг эзэлж байна. Халдварт өвчнөөс цочмог халдварт өвчний гаралт буурч байгаа ч бэлгийн замаар дамжих халдвар болон сүрьеэний өвчлөл өсөх хандлагатай байна.

2016 оны байдлаар нийт хавдрын оноштой 838 хүн байгаагаас умайн хүзүү, элэг, ходоод, хөхний хорт хавдар ихэнх хувийг эзэлж байна. Эдгээр хүмүүсийн 47,5 хувь нь хавдрын 3, 4 дүгээр шатанд буюу хүнд шатанд орсон хүмүүс байна. Энэ нь иргэдийн эрүүл мэндийн боловсрол муу байгааг харуулж байна.

Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт хүн амын 50-60%-ийг эрүүл мэндийн сургалтанд хамруулж байгаа боловч иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинд төдийлөн ахиц гарахгүй, эрүүл мэндийн дадал хандлагад өөрчлөлт орохгүй, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэх ажил шаардлагын түвшинд хүрэхгүй байсаар байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зардалд нийгмийн эрүүл мэндийн зардал бага, ихэнх хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд зарцуулдаг. Эрүүл мэндийн төвийн 2017-2020 онд хэрэгжүүлэх "Эрүүл мэнд" 2020 хөтөлбөрийг

боловсруулан салбарын хэмжээнд удирдлагын болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж, хүн амд нотолгоонд тулгуурласан, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тэгш, чанартай тусламж, үйлчилгээ хүргэн, дүүргийнхээ нийт хүн амын эрүүл мэндийг сайжруулж, чанартай тусламж үйлчилгээг үзүүлж өвчлөл эндэгдлийг бууруулах зорилт тавин ажиллаж байна.

МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Эрүүл мэндийн чиглэлээр гарсан хууль, тогтоомжууд, Монгол улсын эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөр, стратегиуд, Засгийн газрын болон нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх эрүүл мэндийн зорилтуудад үндэслэн "Эрүүл мэнд 2020" хөтөлбөрийг боловсруулан гаргаж байна.

Эрх зүйн орчин: Монгол улсын үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2-р сард баталсан "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" тогтоол

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Орчин үеийн стандарт, шаардлага, мэдээлэл технологийн ололтод тулгуурласан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоог нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Зорилт 1

Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, эсэн мэнд амаржихуй, гэрийн эргэлтийг чанаржуулах, өвчлөлийг хянах, эрүүлжүүлж эмчлэх;

1 дүгээр зорилтын хүрээнд:

1. Жирэмсэн эхчүүдэд зориулсан сургалтын модуль боловсруулан тогтмолжуулж, үр дүнг тооцон ажиллах;
2. Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмж, орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах;
3. Нярайн асаргаа сувилгаа, "Нялх хүүхдийг ойлгох нь", "Хүүхдэд эрт үед үзүүлэх тусламж" сургалтыг тогтмолжуулах, үр дүнг тооцох;
4. Жирэмсэн эмэгтэйчүүдэд эрүүл мэнд, нийгэм орчны үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээ, тусламж үйлчилгээг багаар үзүүлж, төрөлтөнд бэлтгэх шинэ системийг хэрэгжүүлэх;

Хүрэх үр дүн:

- Эх, хүүхэд, өсвөр үеийн охид, оюутан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эсэн мэнд амаржихуйн мэдээлэл сурталчилгаа сайжирна.
- Эх хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, гэрийн эргэлт, зөвлөгөө мэдээлэл сургалт сурталчилгаа сайжирна.

Зорилт 2

Халдварт өвчнийг бууруулах, хүүхэд, өсвөр үе залууст ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын байгууллагад суурилсан Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

2 дугаар зорилтын хүрээнд:

1. Халдварт өвчнийг бууруулах иргэдийн оролцоо, үр дүнд суурилсан Гэр үнэлгээ, CLTS аргачлалуудыг хэрэгжүүлж, үр дүнг тооцох;
2. Хүүхдийн байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчтай хүүхэд, өсвөр насныхны эрүүл мэндийг дэмжих, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр тодорхой ажлуудад гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах;
3. Дүүргийн хэмжээнд "Эрүүл мэндийг дэмжигч боловсролын байгууллага" шалгаруулах уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцох, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох;
4. Өсвөр үе, залууст ээлтэй тусламж үйлчилгээний чиглэлээр оюутан, сурагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг боловсрол олгох, эрүүл мэндийн үзлэг, БЗДХ-ын оношилгоо, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
5. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн гар, шүд угаах дадлыг хэвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, өдөрлөгийг тогтмолжуулах;
6. Халдварт өвчний тархалтыг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ариутгал халдавргүйжүүлэлт хийх, мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах

Хүрэх үр дүн

- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, халдварт өвчин дүүргийн хэмжээнд буурна.
- Хүүхдийн байгууллагуудын ариутгал халдваргүйтгэлийн байдал, түүнд тавих хяналт сайжирч хүүхдийн байгууллагын халдварт өвчин буурна.
- Өсвөр үе, залуусын НҮЭМ, БЗДХ-ын талаар мэдлэг, хандлага сайжирч, өвчлөл буурна.

Зорилт 3

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг эрчимжүүлж хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрт илрүүлж, эмчлэх;

3 дугаар зорилтын хүрээнд:

1. Анхан болон хоёрдогч шатанд халдварт бус өвчний эрт илрүүлгийг эрчимжүүлэх, эрүүл мэндийн тусламжийн шатлал хоорондын уялдаа холбоог сайжруулах;
2. Халдварт бус өвчний идэвхтэй илрүүлгийг зохион байгуулах, дүүргийн албан байгууллагуудад өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах, үр дүнг тооцох;
3. Цэргийн насны залуучуудын эрүүлжүүлэлтийг сайжруулах чиглэлээр ӨЭМТ-үүдэд үүрэг өгч, хяналт тавьж үр дүнг тооцон ажиллах;

4. Хавдраас урьдчилан сэргийлэх ХБӨ-ний эрт илрүүлгийн үзлэгт шаардлагатай тоног, төхөөрөмж, тест урвалж бодисоор хангах ажилд дэмжлэг үзүүлэх;
5. Хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор дугуйн зам, талбай, тоног төхөөрөмж, хэрэгслийн хүртээмж, чанар, гудамж талбайн гэрэлтүүлэг, аюулгүй байдлыг сайжруулах замаар хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;
6. Архи, тамхинаас татгалзах, цусны даралт, илүүдэл жинг бууруулах, таргалалтын хам шалтгааныг тодорхойлон эрсдэлтэй бүлгийн хүн амд зориулсан сургалт сурталчилгааны аянг өрнүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;
7. Аж ахуй нэгж албан байгууллагуудын ажилтан албан хаагчдыг ажлын байрны дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх ажлыг зохион байгуулах;
8. Хүүхдийн байгууллагуудын төсвийн шууд захирагчидтай гэрээ байгуулахдаа хүүхэд өсвөр насныхны эрүүл мэндийг дэмжих, гар угаах орчин нөхцлийг сайжруулсан байдал, амны хөндийн өвчлөлийг бууруулах чиглэлээр ажил зохион байгуулах, эрүүлжүүлэлт хяналтыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах;
9. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих аян өдөрлөг, сургалт сурталчилгааг тогтмолжуулах;
10. Дүүргийн иргэдийн явган аяллын маршрут гаргах сар тутам алхалт зохион байгуулах

Хүрэх үр дүн:

- Зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах нийгэм, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бий болж тасралтгүй байдал, чанар, хүртээмж нь дээшилнэ.
- Залуучуудын эрүүл мэнддээ анхаарах зөв дадал, хэвшил бүрдэж, цэргийн хэрэгт суралцсанаар цэрэг эх оронч хүмүүжил дээшилж, цэргийн дайчилгааны даалгавар биелүүлэх боломж нэмэгдэнэ.
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, амьдралын зөв дадал хандлага төлөвшиж, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөл, хүндрэл, нас баралт буурна.

Зорилт 4

Мэдээлэл технологийн дэвшилтэд тулгуурлан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах;

4 дүгээр зорилтын хүрээнд:

1. Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг өндөр хурдны интернетийн шилэн кабелд холбох, eHealth программ хангамжийг нэвтрүүлэх, ашиглалтыг сайжруулах;

2. Эмнэлгийн хөдөлмөр магадлалын комиссын хурлыг телемедицинд холбож, хурдан шуурхай явуулах талаар туршилт хийх, шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлэх, орчин нөхцлийг сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах;
3. Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг байгуулах, хөгжүүлэх, өвчний цахим түүх нэвтрүүлэх;
4. Эрүүл мэндийн төвийн мэдээллийн санг дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн сантай уялдуулж шинэчлэх, эрүүл мэндийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээгээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

Хүрэх үр дүн

- Эрүүл мэндийн мэдээллийн технологийн дэвшилтэд тулгуурлан хүн амын эрүүл мэндийн нэгдсэн сантай болно.
- Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалтын чадавх сайжирсан байна.

Зорилт 5

Эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн орчин нөхцлийг сайжруулах, стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг чадваржуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

5 дугаар зорилтын хүрээнд:

1. Өрхийн эрүүл мэндийн төвийн ажлыг хагас, бүтэн жилээр иргэдэд тайлагнаж, иргэдийн саналыг ажил дүгнэхэд харгалздаг байх;
2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан "Гүйцэтгэлийн гэрээ"-г хагас бүтэн жилээр дүгнэн, нийслэлийн Эрүүл мэндийн газарт санал хүргүүлж, орон нутгийн түвшинд хариуцлагын механизмыг нэвтрүүлэх;
3. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран жилд 1 удаа Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийлгэх;
4. Анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд улирал тутам хуваарь гарган, зөвлөн туслах;
5. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг MNS5292:2017 стандартын хүрээнд бүтэц, орон тооны дагуу ажиллуулах, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, тасралтгүй, тогтвор суурьшилтай байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;
6. Гар утасны технологид суурилсан эрүүл мэндийн үйлчилгээг ӨЭМТ-үүдэд шат дараатай нэвтрүүлэх, ӨЭМТ-ийн иргэдэд хүрч үйлчлэх ажлыг сайжруулж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
7. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг "Магадлан итгэмжлэл"-д хамруулах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлэх;
8. Эрүүл мэндийн байгууллагуудын байрны урсгал засвар, өргөтгөх, шинэчлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;
9. Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;

10. 12 дугаар хорооны "Жишиг" ӨЭМТ-ийг шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөцөөр ханган, үйл ажиллагааг тогтмолжуулж, бусдад туршлага түгээх ажлыг зохион байгуулах;
11. "Салбар амбулатори 2"-ын барилгын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, актлагдсан барилгыг нураах, дахин эмнэлгийн стандартад нийцсэн барилгыг бариулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
12. "Хүүхдийн нэгдсэн эмнэлэг"-ийн барилгын зураг төсвийг батлуулж, барилгын ажлыг эхлүүлэхэд орон нутгийн түвшинд бүх талаар дэмжин хамтран ажиллах;
13. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрсөн болон жирэмсэн эх, нярайн гэрийн эргэлт, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг цаг тухайд нь чанартай үзүүлэх зорилгоор автомашины парк шинэчлэлийг хийх;
14. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих, зорилтот бүлгийн хүн амд сэргээн засах болон сувилахуйн тусламж үйлчилгээ, гэрийн асаргаа сувилгааг чанартай, хүртээмжтэй үзүүлэх орчин нөхцлийг сайжруулах;
15. "Чадварлаг залуу эмч" аяныг зохион байгуулж, шинэ залуу эмч нарын идэвх санаачилга, ажлын туршлага солилцох, тогтвортой ажиллах боломж нөхцөлөөр хангах, дэмжих;
16. Хамтын ажиллагаатай байгууллага, эмнэлэг, сургуулиудтай хамтран мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын урт, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах;
17. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлага, ёс зүйд анхаарч хариуцлага хяналтын тогтолцоог сайжруулах, үр дүнг тооцох;
18. Эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, нийгмийн батлагааг хангах, ахмад-залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, ахмад эмч нарыг дэмжих;
19. Бусад салбарт ажиллаж байгаа эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдыг чадваржуулах, дэмжлэг үзүүлэх;

Хүрэх үр дүн

- Иргэд, үйлчлүүлэгчид ээлтэй, таатай орчин бүрдэнэ.
- Шинэ оношилгоо, эмчилгээний арга технологи нэвтрүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.
- Хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх, эмч, ажилчдыг дэмжих, урамшуулах механизм бүрдсэнээр чадварлаг хамт олон бүрдэж, үйлчлүүлэгчдэд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж тусламж үйлчилгээний чанар сайжирч, дээд шатны төв эмнэлэгт хандах иргэдийн тоо буурна.

Зорилт 6

Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сайн дурын үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэдийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжин ажиллах;

6 дугаар зорилтын хүрээнд:

1. "Эрүүл ажлын байр" бүрдүүлэх чиглэлээр дүүргийн төрийн байгууллага, аж ахуй нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагчдад эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сургалт сурталчилгаа зохион байгуулж ажиллах;
2. Дүүргийн хэмжээнд Эрүүл мэндийг дээдлэгч өрх, иргэн, Аж ахуй нэгж байгууллагыг шалгаруулах, тэдний үйл ажиллагааг сурталчлах;
3. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчин эмгэгээс сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сайн дурын бүлэг, аж ахуйн нэгж байгууллага, хамт олон, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих;
4. Эрүүл мэндийн сайн санааны туслагч нарын тоог нэмэгдүүлэх, чадваржуулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд оролцуулж ажиллах, үр дүнг тооцон ажиллах, урамшуулал дэмжлэг үзүүлэх;

Хүрэх үр дүн:

- Эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэх талаар чадавх дээшлэн "Эрүүл мэндийг дэмжигч" иргэн, өрх, байгууллага, хамт олон, үйлдвэрлэл, үйлчилгээний тоо нэмэгдэж хүн амын дунд эрүүл зан үйл төлөвшин эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшин буурна.
- Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн ажиллуулах хөтөлбөр эрчимжсэн байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, зарчмууд

- Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал
 - ✓ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан эрүүл мэндийн тусламжийг жигд хүргэх, өрх гэр, олон нийт нь эрүүл мэндийн анхан шатны байгууллагатайгаа нягт холбоотой, 2 дугаар шатлалын тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллахад анхаарна.
- Тэгш байдал
 - ✓ Хүн бүрт яс үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал, бие бялдрын байдлыг харгалзахгүй жендерийн мэдрэмжтэйгээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаанд жигд хамруулна.
- Тусламж үйлчилгээний чанарын баталгаа
 - ✓ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нотолгоонд тулгуурласан стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр стандарт удирдамжийн дагуу үзүүлнэ.
- Үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэх
 - ✓ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан, үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгөх, сонголт хийх, тэдэнд нууцаа хадгалуулах, хүндэтгүүлэх, эрхийг олгож, нууцыг хадгалж, сэтгэл ханамжтай тусламж үйлчилгээг үзүүлнэ
- Уялдаа холбоотой

- ✓ Эрүүл мэндийн байгууллага болон иргэдийн хамтын ажиллагааг дэмжих, эрүүл мэндийг дэмжигч иргэн, өрх, байгууллага, аж ахуй нэгжийн үүсэл санаачлагийг дэмжин үйл ажиллагаагаа нягт уялдуулан, цогц ажиллана.

Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

2017 - 2020 онд хэрэгжүүлнэ.

- Хөрөнгийн эх үүсвэр
 - Улс, нийслэлийн төсөв
 - Дүүргийн төсөв
 - Олон улсын байгууллагын төслийн хөрөнгө оруулалт
 - Бусад эх үүсвэр

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд удирдлага төлөвлөлтөөр Засаг даргын Тамгын газар, Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс ханган ажиллана.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, холбогдох журам, хөрөнгийг дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлнэ.
3. Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв нь хороо, аж ахуйн нэгж, байгууллагыг арга зүйгээр хангаж манлайлан оролцоно.
4. Хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд иргэд, төрийн байгууллага, хороо, аж ахуйн нэгж байгууллага хэрэгжүүлэн ажиллана.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Хяналт шинжилгээ, үнэлгээ

- Дүүргийн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлд хөтөлбөрийн зорилтуудыг тусган хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсээс Эрүүл мэндийн төвтэй хамтран хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж үр дүнгийн тайланг жил бүр гаргаж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

Хөтөлбөрийн үр дүн

- Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрүүл мэнд 2020" хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орчин үеийн стандартын шаардлагад нийцүүлэх, Мэдээлэл технологийн дэвшилтэд тулгуурлан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг багасгах, өвчин эмгэгийг эрт илрүүлэх, төгс эмчлэх, урьдчилан

сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоо нэмэгдэнэ.

Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	2016 оны түвшин	2020 онд хүрэх түвшин
Зорилт 1. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, эсэн мэнд амаржихуй, гэрийн эргэлтийг чанаржуулах, өвчлөлийг хянах, эрүүлжүүлж эмчлэх			
1	Эхийн эндэгдэл, 100000 амьд төрөлтөнд	23.76	0.0
2	Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөнд	11.88	8.0
3	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд	2.61	1.0
4	5 хүртэлх насны өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн хувь	0.05	0.03
5	Хүүхдийн өвчний цогц менежмент, эх, нярайд нэн шаардлагатай тусламж үйлчилгээний тухай сургалтанд хамрагдсан өрхийн эрүүл мэндийн ажиллагсдын тоо	80	100
6	Хүүхдийн түлэгдэлт болон бусад ахуйн осол гэмтлээс сэргийлэх сэдэвт сургалт, сурталчилгаанд хамрагдсан эцэг, эх, асран хамгаалагчдын тоо	5000	15000
7	0-1 насны хүүхдийн гэрийн идэвхтэй эргэлтийн хувь	80	95
8	Жирэмсний эрт хяналтын хувь /Эхний 3 сард/	84.69	90
9	Жирэмсний хяналтын сургалтанд хамрагдсан өрхийн эрүүл мэндийн төв, ЭМТ-ийн эмч, эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын тоо	40	80
10	Жирэмслэлтэд бэлтгэх талаар сургалт, сурталчилгаанд хамрагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо	1000	2000
11	Жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээний хувь	54	60
12	Өсвөр насны охидын жирэмслэлтийн тоо, 15-19 насны	208	150
13	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолддог эмгэгээс сэргийлэх талаар боловсруулсан гарын авлага, сурталчилгааны материалын төрөл, тоо	3 төрлийн 1000 ширхэг	6 төрлийн 6000 ширхэг
14	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хувь	50%	65%
15	Эрхтэн тогтолцооны эмгэгтэй эмэгтэйчүүдийг хяналтанд авч, эрүүлжүүлсэн хувь	1.0%	5.0%
16	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар сургалт, зөвлөгөөнд хамрагдсан өсвөр насныхан болон	750	1500

	оюутан залуучуудын тоо		
Зорилт 2. Халдварт өвчнийг бууруулах, хүүхэд, өсвөр үе залууст ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын байгууллагад суурилсан Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх			
1	Халдварт өвчний үзүүлэлт 10000 хүн амд	268.5	265
2	Хүүхдийн байгууллагуудад Hyegine Promotion Box буюу гарын эрүүл ахуйн ач холбогдол театрчилсан сургалтыг тогтмолжуулсан байдал (хувь)	20%	100%
3	Хүүхдийн байгууллагад гэдэсний халдварт өвчний тохиолдлыг бууруулах, голомтлон гаргахгүй байх	150	75
4	Хүүхдийн байгууллагын эмч нарт халдварт өвчний талаарх мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол хийж хэвшсэн байх /сургалт, уулзалтын тоо, давтамж/	18	36
5	Бэлгийн замын халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд	49.8	40.0
6	Тэмбүү өвчний тархалтын түвшин 10000 хүн амд	29.6	20.0
7	Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүүгийн тархалтын хувь /шинэ тохиолдлоор/	0.9%	0.5%
8	Тэмбүү өвчнөөр оношлогдсон жирэмсэн эмэгтэйчүүдийн эмчилгээнд хамрагдсан хувь	98.0	100.0
9	Сайн дурын зөвлөгөө шинжилгээнд хамрагдсан тоо	750	1500
10	Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо	6000	10000
11	Халдварын сэргийлэлт, хяналтын идэвхтэй дэмжлэгт хяналтанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	17	17
Зорилт 3. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг эрчимжүүлж хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрт илрүүлж, эмчлэх			
1	Нэг жилд зохион байгуулсан олон нийтийг хамарсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны компани үйл ажиллагааны тоо	2	6
2	Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт сэдвээр танхимын сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажиллагсдын тоо	25	150
3	Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт сэдвээр сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүн амын тоо	400	2000
4	Артерийн даралт ихдэх өвчний эрт илрүүлгийн хувь	60.4	80.0
5	Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хувь	59.6	80.0
6	Хөх, Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн хувь /30-60 насныханд/	33.5	60.0
7	Эрт илрүүлгээр илэрсэн ХБӨ-ний тохиолдлыг хяналтанд авсан хувь	89.0	100.0
8	Хавдрын шалтгаант нас баралт 10000 хүн амд	13.24	13.0

Зорилт 4. Мэдээлэл технологийн дэвшилтэд тулгуурлан анхан болон хоёр дахь шатлалын тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах

1	ЭМТ-тэй шилэн кабель болон нэгдсэн программд холбогдсон ӨЭМТ-ийн тоо	0	16
2	Хөдөлмөр магадлалыг комиссын онлайн хуралд холбогдсон ӨЭМТ-ийн тоо	0	16
3	ХЧА-ыг онлайнаар шийдвэрлүүлсэн хүний тоо /жилд/	0	500
4	Эрүүл мэндийн мэдээллийн удирдлага, статистикийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлсэн байдал	10%	100%
5	Цахим эрүүл мэндийг хөгжүүлэх замаар эрүүл мэндийн мэдээллийн удирдлага, статистикийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлсэн байдал (хувь)	5%	100%
6	Цахим бүртгэл, иргэдийг угтах үйлчилгээний орчин нөхцлийг сайжруулсан байдал (хувь)	10%	100%
7	Хүн амын эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сангийн баяжуулалтын хувь	17%	100%

Зорилт 5. Анхан болон хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг үзүүлэх, Эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн орчин нөхцлийг сайжруулах, стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг чадваржуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх

1	Шинээр ашиглалтан орсон Зориулалтын байртай ӨЭМТ-ийн тоо	1	3
2	Дүүрэгт ашиглалтад хүлээн авсан эрүүл мэнд төвийн барилгын тоо	0	3
3	ЭМТ, ӨЭМТ-ийн эмч ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан, олгосон санхүүжилтийн хэмжээ	15 сая	60 сая
4	Мэргэжлийн чиглэлээр гадаадад богино, дунд хугацааны сургалтанд хамрагдсан эмнэлгийн ажилтнуудын тоо	10	30
5	Орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал	-	Тайлангаар
6	Магадлан итгэмжлэлд хамрагдсан байдал ӨЭМТ-ийн тоо	2	16
7	Сэтгэл нийцсэн 8 үйлчилгээг хэвшүүлсэн байдал	-	Тайлангаар
8	Гадаад, дотоод орчны аюулгүй байдалдаа ахиц гаргасан эрүүл мэндийн байгууллагын тоо	3	10

Зорилт 6. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сайн дурын үйл ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэдийн үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжин ажиллах

1	Эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагын тоо	12	30
2	Эрүүл мэндийн сайн санааны туслагч нарын тоо	130	200
3	Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр байгуулагдсан иргэдийн бүлгүүдийн тоо	5	20
4	Иргэдийн оролцоотой эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний оролцсон хүний хувь	20 хувь	30 хувь



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

"Жаргалтай гэр бүл" хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийгэм дэх сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх замаар гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, аж төрөх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100071

0:2017/Тогтоол

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралт



“ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичигт “Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ”, “Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан. Мөн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зэрэгт гэр бүл, хүүхдийн эрх, хамгааллын талаар тусгагдсан байдаг.

Гэр бүл нь үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндэс, улс орны хөгжил дэвшлийн баталгаа төдийгүй төр улс дотор оршин буй гэр бүл нь үндэсний ёс заншил, соёл уламжлал, үнэт зүйл өвлөгдөн хадгалагддаг хүний хөгжил төлөвшлийн суурь орчин байдаг.

“Гэр бүлийн өнөөгийн байдал, амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлт чиг хандлага” судалгааны дүнгээс үзэхэд гэр бүлийн харилцааны шинж байдлын эрчимтэй өөрчлөлтийг даган хосууд гэрлэлтээ бүртгүүлэх асуудалд хайнга хандах болсноор “хамтран амьдрагчид”-ын тоо жилээс жилд нэмэгдэн, эрх зүйн чадамжгүйгээс гэр бүлийн хариуцлага буурч, хүүхдийн эрх зөрчигдөх зэрэг олон хурц асуудлууд нийгэмд гарч байна.

Түүнчлэн залуу гэр бүл бологсад хангалттай бэлтгэгдээгүйгээс гэр бүл салах, салсны дараа үр хүүхэддээ тавих анхаарал халамж дутах, хүүхдээ авч үлдсэн гурван хүн тутмын хоёрт нь хариуцлага ачаалал нэмэгдэж, түүнийг даган хүүхдийн гэр бүлдээ аав, ээжтэйгээ эрүүл аюулгүй орчинд амар тайван амьдрах эрх нь зөрчигдөж, хүүхдийн хөгжил төлөвшилд сөргөөр нөлөөлж байна.

2016 оны мэдээгээр дүүргийн хэмжээнд эрсдэлт бүлгийн 304 хүүхэд байгаагаас хүүхэд хамгааллын үйлчилгээнд 940 хүүхэд, гэр бүл хамгааллын үйлчилгээнд 1025 эцэг эх, 25 хүүхэд (давхардсан тоогоор) хамрагдсан. Мөн 2016 онд 936 гэр бүл бүртгэгдэж, 325 гэр бүл цуцлалт хийгдсэнээс гадна улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэрэг 1331 бүртгэгдэж өмнөх оныхоос 8,3 хувиар өссөн байна.

2017 оны 1 дүгээр сарын байдлаар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс нийт 962 хүнд хүрч ажиллажээ. Хүүхдийн 108 дуудлагын утсанд 23 удаагийн дуудлага ирж 30 хүүхэд зохих үйлчилгээ, зөвлөгөө, мэдээлэл авсан бол нийт 27 удаагийн кейс дээр ажилласнаас бие махбодийн хүчирхийлэл 14, бэлгийн хүчирхийлэл 1, үл хайхрах хүчирхийлэл 13, шинжээчийн дүгнэлт 3, гэр бүлийн хүчирхийлэл 8, сэтгэл санааны хүчирхийлэл 2, хүүхдийн эрхийн зөрчил 1 тус тус гарсан байна.

Дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 564 хүүхэд байгаагаас сургуулийн өмнөх боловсролд 23, сургуульд 256 хүүхэд хамрагддаг, тэдний эцэг эхийг бүлэг зохион байгуулалтад оруулан ажил хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх нөхцөл бололцоог нэмэгдүүлэх зорилгоор "Шинэ хос номин оюу", "Гэгээлэн" зэрэг ТББ-тай хамтран 45 хүүхдийг асарч хөгжүүлж байгаа ч хамрагдалтыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Иймд "Жаргалтай гэр бүл" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Нийгэм дэх сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх замаар гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, аж төрөх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд, хүрэх үр дүн

Зорилт 1

Хүүхдийн хөгжлийн бүхий л түвшний хэрэгцээг хангаж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, менежментийг сайжруулах

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Хүүхдийн хөгжлийг хангах

1. Хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжих, идэвхтэн сурагчдаар дамжуулан бусад сурагчдад нөлөөлөх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах;
2. Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдэд тулгамдаж буй асуудал, хүүхдийн санал хүсэлтийг төрийн байгууллагын бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжүүлэх, тэдний эцэг эхчүүдийг бүлэг зохион байгуулалтад оруулж хөдөлмөр эрхлүүлэх, эцэг эхийн оролцоо хандлагыг өөрчлөх, идэвхжүүлэх;
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч хөгжүүлэх, боловсрол олгоход чиглэсэн төр, төрийн бус байгууллага, ахуйн нэгж байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжих;
5. Хүүхдийг аливаа эрсдэл, хорт зуршил, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотой зохион байгуулах;

Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах

6. Хүүхдийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулан, гэмт хэрэгт өртсөн, өртөж болзошгүй хүүхдүүдийг хууль эрх зүйн мэдээллээр хангах, тэднийг амьдралын зөв дадалд сургах;
7. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн мэдээллийн санг шинэчилж, тэдэнд сэтгэл зүйн болон амьдрах ухааны сургалтуудыг явуулах, хүүхдийг тэвчишгүй хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
8. Зорилтот бүлгийн хүүхдийн хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хараа хяналтгүй хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг эрчимжүүлэн ажиллах;

9. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус, олон улсын байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах;
10. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгосон, үрчлэгдсэн хүүхдүүдийн эрхийг хамгаалах, хяналт тавих ажлын зохион байгуулалт, менежментийг сайжруулах;

Хүрэх үр дүн:

Хүүхдийн хөгжлийг хангах

- Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх чуулган, хэлэлцүүлэг, өдөрлөг уулзалт зохион байгуулж тэдний санал хүсэлт шийдвэр гаргах түвшинд хүрсэн байна.
- Дүүргийн хүүхдийн холбоо, сурагчийн өөрөө удирдлагын байгууллагын сурагчдаар дамжуулан нөлөөллийн ажил зохион байгуулагдаж, идэвхтэн сурагчдын тоо нэмэгдсэн байна.
- Хороо бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн зөвлөл байгуулж, тэдний оролцоотой нийгэм дэх оролцоо, эцэг эхчүүдийн харилцаа хандлагад эерэг өөрчлөлт орсон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь нэмэгдсэн байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах

- Хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх, бүртгэлжүүлэх, ар гэрт нь эргэн нэгтгэх, нийгэмшүүлэх нэгдсэн арга хэмжээг жил бүр зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна.
- Хөдөлмөр эрхлэгч хүүхдийн мэдээллийн сан шинэчлэгдэн суурь судалгаатай болж, тэдний сурч боловсрох эрх нь хангагдаж, амьдралын зөв дадал хэвшилд сургах сургалтыг улирал бүр зохион байгуулсан байна.
- Хараа хяналтгүй болон хараа хяналт сул, эрсдэлтэй, зорилтот бүлгийн хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, сургууль цэцэрлэгт оруулах, хүүхдийн зусланд амруулах ажлыг жил бүр тогтмол хийж, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж, сурч боловсрох болон хүүхдүүдийн эрхийг хангах ажлыг зохион байгуулсан байна.

Зорилт 2

Гэр бүлийн хөгжил, тогтвортой, үнэнч байдал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих

Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Гэр бүлийн хөгжлийг дэмжих

1. Гэр бүлийн соёл, сайн туршлагыг олон нийтэд сурталчлах чиглэлээр уралдаан, тэмцээн, урлаг, спорт, соёлын арга хэмжээ зохион байгуулах;
2. Залуу, дунд, ахмад үеийн гэр бүлийн уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах;
3. Гэр бүлд (хүүхэд) зөвлөгөө өгөх өрөө танхимыг хороодод байгуулан үйл ажиллагааг нь дэмжих;
4. "Ачлалт аав", "Энэрэлт ээж", "Шилдэг гэр бүл"-ийг шалгаруулан алдаршуулах, сурталчлах, нөлөөллийн ажлуудыг төрийн бус мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулах;.

5. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг түшиглэсэн гэр бүлийн боловсрол олгох, залуучуудын мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах, тэдний үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих;

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх

6. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж, дамжин өнгөрүүлэх байртай болох;
7. Зорилтот бүлгийн гэр бүлийн гишүүдийг хөгжүүлэх, эцэг эх, хүүхэд хоорондын харилцаа, үүрэг хариуцлагыг сайжруулах сургалт сурталчилгаа, зөвлөгөө мэдээлэл өгөх үүрэг бүхий клубыг хороо бүрт байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих;
8. Архи, мансууруулах бодис, хорт зуршлаас татгалзах зан үйлийг төлөвшүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах;

Хүрэх үр дүн

Гэр бүлийн хөгжлийг дэмжих

- Гэр бүлийн чиглэлээр хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, гэр бүлүүдийг идэвхжүүлэх үйл ажиллагаануудыг улирал бүр зохион байгуулж, гэр бүлийн өдрөөр гэр бүлүүдийн сайн туршлагыг нийтэд сурталчлах ажлыг тогтмол хийж заншсан байна.
- Хороо бүр хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх өрөөтэй болж, үйл ажиллагаа нь тогтворжсон байна.
- Жил бүр Шилдэг гэр бүлүүдийн сайн туршлагыг сурталчлах бусдад нөлөөлөх нөлөөллийн ажлууд зохион байгуулагдсан байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх

- Гэр бүлд хүний эрхийг хүндэтгэн үзэх хандлага гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг хороо бүрт улирал тутам зохион байгуулсан байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс асуудлаа даван туулах чадвартай болно.
- Архины хэрэглээний түвшин тогтоох судалгааг хороо бүрт жил бүр авч, дүн шинжилгээ хийн ажиллаж, хамааралтай иргэдийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх архинаас татгалзах зан үйлийг төлөвшүүлэх ажлыг ТББ-тай хамтран зохион байгуулсан байна.

Зорилт 3

"Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж чадваржуулах,

Зорилт "-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. "Хамтарсан баг"-ийн гишүүдийг чадваржуулах сургалтыг үе шаттай явуулах, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах олон талт үйл ажиллагаа зохион байгуулах;
2. "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг дэмжин гишүүдийг урамшуулах, үйл ажиллагааны зардлын тооцоо судалгааг хийх, зохих түвшинд шийдвэрлэх;
3. Хүүхэд, гэр бүл хамгааллын мэдээлэл, үйлчилгээний тэмдэглэл, хүүхдэд учирсан эрсдлийн түвшин, хүүхэд ба гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, үйлчилгээний төлөвлөлт зэргийг хөтлөх үлгэрчилсэн маягт, аргачлалыг боловсруулах, мөрдүүлэх;

Хүрэх үр дүн:

- Хамтарсан багийн гишүүдийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн, байгууллага хоорондын уялдаа холбоо сайжирч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.
- Хамтарсан баг үйл ажиллагааны зардалтай болж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.
- Нийгмийн ажилтны ажиллах орчин нөхцөл сайжирсан байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

- Хөтөлбөрийн зорилго бодитой, зорилтууд хэрэгжихүйц байх;
- Хөтөлбөрийн хэрэгжилт нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлага, иргэд, хүүхэд, олон нийтийн санаачилга, оролцоонд тулгуурласан байх;

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

2017-2020 хүртэл нэг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Санхүүжилт:

- Орон нутгийн төсөв
- Олон улсын болон төрийн бус байгууллагуудын төсөл хөтөлбөр, тусламж
- Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- Хөтөлбөрийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, хороодын Засаг даргын Ажлын алба, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
 - ✓ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс нь "Хамтарсан баг"-ийг арга зүйгээр ханган ажиллана.
 - ✓ Хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх үүргийг цагдаагийн I, II хэлтэс хүлээнэ.
 - ✓ Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад нь "Хамтарсан баг"-ийн хурлын шийдвэрт үндэслэн бүх талын дэмжлэг туслалцааг үзүүлж, хамтран ажиллана.
- Жаргалтай гэр бүл хөтөлбөрийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах ажлыг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс хүлээнэ.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнана.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хагас жил тутам хийнэ.

- Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээг мэргэжлийн байгууллагуудын тусламжтайгаар хийнэ. Хөтөлбөрийн үнэлгээнд бүх талуудыг тэгш хамруулна.

Найм. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллыг сайжруулах талаар хийгдэж буй ажлын үр дүн сайжирч, гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх замаар хүүхдийн аж төрөх таатай орчин бүрдсэн байна.

Ес. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016	Зорилтот түвшин 2020	Хэрэгжүүлэх байгууллага
Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлт					
1	Хүүхдийн оролцоог хангасан чуулга уулзалт, хэлэлцүүлэг	тоо/жил	2	4	НХХ, ГБХЗХХ Хороод, ЕБС-иуд
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	хувь	19%	100%	НХХ, БХ ЕБС-иуд СӨББ-ууд Хороод
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн бүлэг	тоо	-	6	НХХ, ГБХЗХХ ХБИХолбоо
Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт					
4	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх ажилд хамрагдсан хүүхэд	нийт хүүхдээс эзлэх хувь	4,2	4,6	НХХ, ГБХЗХХ
5	Хүүхдийн эрхийн зөрчил	нийт хүүхдээс эзлэх хувь	0,5	0	НХХ, ГБХЗХХ
6	Хөдөлмөр эрхлэгч хүүхэд	тоо	12	0	НХХ, ГБХЗХХ
7	Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажилд хамрагдсан иргэд	тоо/жилд	1025	5000	ГБХЗХХ
8	Зорилтот бүлгийн гэр бүлийн гишүүдийг хөгжүүлэх, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, үүрэг хариуцлагыг сайжруулах сургалт сурталчилгаа, зөвлөгөө мэдээлэл өгөх үүрэг бүхий клуб	тоо	0	19	НХХ ГБХЗХХ Хороод
9	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа	тоо/жил	6	25	НХХ ГБХЗХХ

10	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэн	тоо/жил	20	0	Хороодын ХБаг
11	Архинаас татгалзах зан үйлийн сургалтад хамрагдсан иргэн	тоо/жил	12	24	Хороодын ХБаг
Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт					
12	Хамтарсан багийн гишүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт	тоо/жил	3	7	НХХ



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

"Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Үндэсний өв соёл, түүхээ тээн хөгжүүлэгч, нийслэл хотынхоо өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл явцад оролцох өсвөр, залуу үеийнхнийг бэлтгэж, урлаг, спорт, соёлын ажил үйлчилгээгээр дамжуулан "Хотын зөв иргэн, зөв соёл"-ыг төлөвшүүлэх зорилго бүхий "Хотын иргэн-Хотын соёл" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

11501000039
D:2017 Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт



“ХОТЫН ИРГЭН-ХОТЫН СОЁЛ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн байдал

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 82 дугаар тогтоолоор “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд урлаг соёлын болон соён гэгээрүүлэх 160 үйл ажиллагааг зохион байгуулж, тэдгээрт 40000 гаруй хүүхэд багачууд, иргэдийг хамруулсан. Хөтөлбөр хэрэгжсэнээр хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлууд зохион байгуулагдаж, урлаг соёл, соён гэгээрүүлэх үйлчилгээгээр дамжуулан хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, гоо зүйн хүмүүжил олгох уралдаан тэмцээний тоо нэмэгдэж, чанаржсан. Мөн байгууллагын соёл, гадаад, дотоод тохижилт сайжирч, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдэлж, угийн бичиг тогтмол хөтөлдөг айл өрхийн тоо нэмэгдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай, Боловсролын тухай, Биеийн тамир, спортын тухай болон Соёлын өвийг хамгаалах тухай хууль, соёл, биеийн тамир, спорт, боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлүүдийг үндэслэн иргэдийн хөгжлийг бүх талаар дэмжсэн “Хотын иргэн-хотын соёл” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан.

Хотын соёл, хотын хүмүүжил гэсэн асуудлаар сүүлийн үед судлаачид нэлээдгүй ярьж, нийтлэх болсон. Гэсэн хэдий ч хотын иргэн оршин амьдарч буй хотдоо хэрхэн соёлтой амьдрах талаарх ойлголт мэдлэг, зөв төлөвшил, хандлага дутмаг байсаар байна.

Мэдээлэл судалгааны MMCG компани хотын иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг явуулжээ. Энэхүү судалгаанд нийслэл хотод 6 сараас дээш хугацаатай амьдарч буй 500 өрхийн 18-аас дээш насны хүмүүсийг хамруулсан байна. Чингэлтэй дүүргээс 52 өрх санамсаргүйгээр сонгогдсон бөгөөд 55% нь гэр хорооллын, 45% нь байшин хорооллын өрх хамрагджээ.

Нийгмийн асуудлаар иргэдийн санаа бодол, сэтгэл ханамжийн түвшинг

- Хүрээлэн буй орчин
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Боловсрол
- Аюулгүй байдал
- Хөдөлмөр эрхлэлт

- Нийтийн аж ахуй, нийгмийн үйлчилгээ гэсэн 6 чиглэлээр авч үзэхэд 2,11-2,86 буюу хангалттай сайн биш гэсэн дүн гарчээ. (1-5 хүртэлх түвшингээр үнэлүүлсэн)

Нийслэлийн иргэдийн амьдралын чанар ямар байна вэ? гэсэн асуулгыг судалгаандаа оруулсан байна. “Амьдралын чанар” гэдэг нь хувь хүн болон нийгмийн сайн сайхан байдлыг илэрхийлдэг үзүүлэлт юм. Судалгаанд

оролцогчдын 26% нь эерэг, 59% нь сөрөг, 15% нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Мөн амьдрал сайжирсан гэж 20%, хэвийн гэж 40%, муудсан гэж 32% нь хариулсан байна. Үүнээс гадна нийслэлийн төрийн байгууллагуудын ажил, үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж 2,94 гэсэн үзүүлэлттэй гарчээ.

“Хотын соёл” таны бодлоор гэсэн асуулгад 1% нь маш сайн, 27% нь сайн, 18% нь муу, 3% нь маш муу гэсэн үнэлгээг тавьжээ. Хот соёлгүй байна гэж үзэж буй шалтгаанаа судалгаанд оролцогчид тайлбарлахдаа

- | | |
|--|--------|
| - Хогоо ил задгай хаях | 43% |
| - Харилцааны соёлгүй | 33% |
| - Нус, цэр, шүлсээ олон нийтийн газар хаядаг | 15% |
| - Архидан согтуурах | 12% |
| - Үйлчилгээний болон төрийн байгууллагын хүнд суртал | 9% гэж |

хариулжээ.

“Хотын соёлыг сайжруулахын тулд юу ямар ажил зохион байгуулах нь үр дүнтэй вэ?” гэсэн асуулгад дийлэнх олонх нь хотын захиргаа иргэдийн соёлыг сайжруулах компанчилсан сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран явуулах, олонх нь ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт хотын соёлын хичээлийг оруулах, өсвөр, залуу үеийнхэнд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулах нь зүйтэй гэж хариулжээ.

Иймд “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Хотынхоо өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтийн төлөө хийж бүтээх, хөгжлийн үйл явцад оролцох, нийгмийн идэвхтэй амьдралын хэв маягийг сонгох, мэдээ мэдээллийн төвд байж, шинэлэг санаа, төслийг хэрэгжүүлэх үүрэг зөвхөн хотын иргэн хүнд л оногдоно.

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр их хотын иргэн бүр эрх, үүргээ ухамсарлаж, хотын соёлыг иргэн бүрт төлөвшүүлнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Үндэсний өв соёл, түүхээ тээн хөгжүүлэгч, нийслэл хотынхоо өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл явцад оролцох өсвөр, залуу үеийнхнийг бэлтгэж, урлаг, спорт, соёлын ажил үйлчилгээгээр дамжуулан “хотын зөв иргэн, зөв соёл”-ыг төлөвшүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд, хүрэх үр дүн

Зорилт 1

Сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, сургалтыг дэмжих үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд багачуудад хотын иргэний эрх, үүргийг ухамсарлуулж, хотын соёлд суралцуулах

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

1. “Төсөлт ажил”-аар дамжуулан цэцэрлэгийн хүүхэд багачуудыг амьдралын зөв дадал, хэвшилд сургах хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж хэвшүүлэх, сургалтын үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
2. Ерөнхий боловсролын сургуулийн “Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг”, “Иргэний боловсролын цаг”, “Амьдрах чадварт суралцах цаг”-ийн

сургалтын хөтөлбөрт хотын иргэн, хотын соёлын агуулгыг оруулж, үр дүнг тооцох;

3. "Миний өв соёл-Монгол бичиг мину", "Ургийн бичгээ хөтөлж сурцгаая", "Монгол өв соёлын богц", "Монгол наадгай" зэрэг аян, зорилтот ажлуудыг зохион байгуулж, өв тэгш Монгол хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд орон нутгийн боловсролын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх;
4. Сурагчдын өөрийн удирдлагын байгууллага, дүүргийн Хүүхдийн холбоо, ерөнхий боловсролын сургуулиудын клуб, дугуйлангийн үйл ажиллагаанд тулгуурлан урлаг, спорт, соёлын уралдаан, тэмцээнүүдийг зохион байгуулах, сайн үйлсийн аян, олон нийтийн ажилд идэвхтэй оролцогч, хамтрагч хүүхэд залуучуудыг алдаршуулах, урамшуулах;

Хүрэх үр дүн:

- Хүүхэд багачууд бага наснаасаа хотын иргэний эрх, үүргийн талаарх ойлголт мэдлэгтэй болж хөгжиж төлөвших нөхцөл бүрдсэн байна.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт хотын иргэн, хотын соёлын агуулга тусгагдсан байна.
- Хүүхэд, багачуудад зориулсан урлаг, спорт, соёлын арга хэмжээний хүртээмж, чанар, зохион байгуулалт, оролцоо, хамрагдалт сайжирсан байна.

Зорилт 2

Монгол угсаатан ард түмнүүдийн соёлын солилцоо, харилцаа хамтын ажиллагааг дэмжиж, соёлын үнэт өв, дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, сурталчлан таниулах замаар өсвөр үе, хүүхэд залуучууд, иргэдийг хөгжүүлэх, төлөвшүүлэх

Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Монгол хэл, соёл, зан заншлыг тээгч улс орон, хотуудтай соёлын солилцоо, харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, урлаг, спортын олон улсын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, соёлын өдөрлөгүүдийг зохион байгуулах;
2. Монгол хэл, соёл, зан заншлыг тээгч ард түмнүүдийн түүхийг сурталчлах, соёлын өв, түүх соёлын дурсгалт зүйлсийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх;
3. Соёлын биет болон биет бус өвийг өвлөн тээгч нарын мэдээллийн сан бүрдүүлж, билиг авьяастны улсын жагсаалтад оруулах ажлыг зохион байгуулах;
4. Соёлын биет бус өвийг өвлөн уламжилж буй иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, өвлөн тээгчийн урын санг баримтжуулж, архив үүсгэх, иргэд олон нийтэд сурталчлан таниулах;

Хүрэх үр дүн:

- Монгол угсаатан ард түмнүүд соёлын өвөө хамтран сурталчлах, түгээх боломж бүрдэн, хамтын ажиллагаа хөгжлийн шинэ түвшинд хүрсэн байна.

- Соёлын биет болон биет бус өвийг өвлөн тээгч нарын бүртгэл мэдээллийн сан бүрдэж, соёлын үнэт өв, дурсгалт зүйлсийн үнэ цэнэ, түүхээр дамжуулан хүүхэд залуучуудад Монгол хүн болон төлөвших, соёлтой иргэн болж бэлтгэгдэх орчин бий болно.

Зорилт 3

Эх орон, үндэсний өв соёл, түүхээ судалж, бахархан дээдлэгч, гэр бүл, удмын сангаа хамгаалан ургийн бичиг хөтөлдөг иргэн, өрхийг дэмжих, хөгжүүлэх

Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Цэрэг, эх оронч үзэл, тусгаар тогтнолын үнэ цэнэ, үндэсний аюулгүй байдлын асуудлаар өсвөр үе, залуучуудад яриа таниулга, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
2. Эх хэл, бичиг соёлоо сурталчлах, номтой нөхөрлөх зорилтот ажлуудыг иргэдийн оролцоотой зохион байгуулж;
3. Монголын түүх, хэл бичгийн соёл, ёс заншил, өв уламжлалаа таниулах, хөгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, нийгэм, гэр бүл, боловсролын байгууллагыг дэмжлэгийг авч ажиллах;
4. Үндэсний аюулгүй байдал, Монгол хүний удмын санг хамгаалах, цус ойртолтоос сэргийлэх, удам угсаагаа мэдэх хүрээнд “Ургийн бичиг хөтлөх” ажлыг эрчимжүүлж, хөтлөгч өрхийн тоог нэмэгдүүлэх;

Хүрэх үр дүн:

- Эх оронч үзэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаагаар дамжуулсан сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлууд тогтмолжиж, төрөлх хотоо, амьдрах орчноо хайрлан хамгаалах үзэл, төлөвшилтэй хүүхэд, залуучуудын тоо нэмэгдсэн байна.
- Эх хэл, бичиг соёл, эх түүхээ судалдаг хүүхэд залуучууд, иргэдийн тоо нэмэгдэж, үндэсний өв соёлд суурилсан хотын соёлыг төлөвшүүлэх чиг хандлага бий болж, нутагшина.
- Ургийн бичиг хөтөлж хэвшсэн өрхийн тоо нэмэгдэж, Монгол хүний удмын сан хамгаалагдана.

Зорилт 4

Үйлчилгээний соёлыг хэвшүүлсэн, үйлчлүүлэгчээ дээдэлсэн байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжих, ахуйн соёл, нийтийн соёл, байгууллагын соёлын үзэл санааг нэвтрүүлэх, хэвшүүлэх

Зорилт 4-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, бүх шатны боловсролын байгууллагуудын орчны тохижилтыг сайжруулахад анхаарч, тухайн байгууллагын эзэмшлийн зам талбай дахь ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;
2. Харилцааны соёл, ахуйн соёл, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, болзолт уралдаан, аян зарлан идэвхжүүлэх;
3. Гудамж, талбай, айл өрхийн орчны өнгө үзэмжийг сайжруулах, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, ногоон байгууламж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх;

4. Иргэдийн соёл, хөгжлийн хэрэгцээний судалгааг гарган, нийтийн соёлыг дээшлүүлэхэд хороо, айл өрх, аж ахуйн нэгжийн дунд хөдөлгөөн өрнүүлэн, уялдаа холбоотой хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
5. Иргэдийн хөгжлийн хэрэгцээнд түшиглэсэн урлаг, спорт, соёл, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэний танхимыг түшиглэн явуулж тогтмолжуулах, иргэдийг сонирхлын бүлгээр нь сайн дурын хамтлаг, урлагийн клубууд байгуулан ажиллахад дэмжлэг үзүүлэх;

Хүрэх үр дүн:

- Харилцааны соёл, ахуйн соёл, нийтийн соёл, үйлчилгээний соёл, байгууллагын соёл нь "Хотын соёл"-ын салшгүй нэг хэсэг болж хөгжсөн байна.
- Үйлчлүүлэгчээ дээдэлдэг, харилцааны соёлыг хэвшүүлсэн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын тоо нэмэгдэж, байгууллага хоорондын хамтын ажиллагааны шинэ жишиг бий болно.
- Орчны жишиг тохижилтын загварууд бий болж, хотын өнгө үзэмжид нөлөө үзүүлнэ.

Зорилт 5

Хотын иргэний соёлыг төлөвшүүлэх талаар иргэдэд сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах, урлаг, соёл, спорт, сайн үйлс бүтээх ажлаар дамжуулан хүмүүжил олгох

Зорилт 5-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Өсвөр үе, залуучуудад зориулсан амьдрах ухааны болон мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулж, сайн үйлсийн аян, нийгэмд эерэг зан үйлийг бий болгох чиглэлээр санаачилсан үйл ажиллагааг дэмжиж ажиллах;
2. Дүүргийн нийт иргэдийн дунд "Хотын иргэн-Хотын соёл" хөдөлгөөн өрнүүлэх, хотын иргэний эрх, үүргийн талаар мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгэм, соёлын харилцаанд татан оролцуулж идэвхжүүлэх, тэдний авьяасыг нээн хөгжүүлэх;
4. Иргэдэд иргэний үүргээ биелүүлэх ухамсрыг төлөвшүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн оролцоо дэмжлэгийг авч ажиллах, бусдын эрх зөрчигдөж буй, соёлгүй зан үйлүүдийн хэвшил, дадал, зуршлыг арилгах нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэх;
5. Бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах ажлыг судалгаанд суурилан зохион байгуулах;
6. Иргэдийн авьяас чадварыг дэмжин, урлаг, спорт, соёлын наадам зохион байгуулах, түүх соёл уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд оролцох оролцоог дэмжих;

Хүрэх үр дүн:

- Орон нутгийн зүгээс иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх компанчилсан сурталчилгааны ажлыг хэвшүүлсэн байна.

- Иргэний үүргээ биелүүлдэг, урлаг, спорт, соёл, олон нийтийн ажилд сайн дураар оролцдог иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, зарчмууд

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтална.

Тасралтгүй, залгамж холбоотой байх

- Хүүхдийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, эх түүх, уламжлалаа нандигнан дээдэлдэг "Хотын соёлтой иргэн" болгон төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг дэмжиж, хамтарч ажиллана.

Уялдаа холбоотой байх

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, төрийн бус, олон улсын байгууллага, аж ахуй нэгжийн хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэдэд иргэний үүргээ биелүүлэх ухамсрыг төлөвшүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн оролцоо дэмжлэгийг авч ажиллана.

Тэгш, хүртээмжтэй байх

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгэм, соёлын үйл ажиллагаанд хамруулах, идэвхтэй оролцуулах, урлаг, спорт, соёл, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхэд, залуучууд, гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангаж ажиллана.

Шинийг санаачлагч, бүтээгч байх

- Өсвөр үе, залуучуудад зориулсан бүх төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сайн үйлсийн аян, нийгэмд эерэг зан үйлийг бий болгох чиглэлээр санаачилсан үйл ажиллагаа бүрийг дэмжиж ажиллана.

Үндэсний өв соёлд тулгуурлах

- Гэр бүлийн соёл, хүмүүжил, уламжлалыг дээлэх, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, сурталчлах нь хотын соёл, хотын иргэн төлөвших нэг тулгуур байх зарчим баримтална.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

"Хотын иргэн-Хотын соёл" хөтөлбөрийг 2017-2020 оны хооронд хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улс, нийслэлийн төсөв
- Орон нутгийн төсөв
- Төрийн бус, олон улсын байгууллагын дэмжлэг, хандив тусламж
- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд удирдлага төлөвлөлтөөр Засаг даргын Тамгын газар, Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс ханган ажиллана.

- ✓ Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хөтөлбөрийг дэмжиж, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө жил бүр тусган хэрэгжүүлнэ.
- ✓ Боловсролын хэлтэс, Соёлын төв, Биеийн тамир спортын хороо, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр халамж

үйлчилгээний хэлтэс, хороодын Засаг даргын Ажлын алба нь харьяа байгууллага, аж ахуй нэгжийг арга зүйн удирдлагаар хангаж, манлайлан ажиллана.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилго-зорилт, үйл ажиллагааны холбогдох журам, дүрэм боловсруулах, хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн түвшинд шийдвэрлэхэд дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг туслалцаа, оролцоог хангаж ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Хяналт шинжилгээ, үнэлгээ

- Дүүргийн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хөтөлбөрийн зорилтуудыг тусган хэрэгжүүлнэ.
- Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч бүх талуудын тэгш оролцоог ханган хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж үр дүнгийн тайланг жил бүр гаргаж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнана.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны үр дүнгээр нь үнэлнэ.

Хөтөлбөрийн үр дүн

- Хүхэд багачуудад бага наснаас нь хотын иргэний соёл төлөвшиж, эрхээ эдэлж, үүргээ ухамсарлах ёс зүйтэй болсон байна.
- Монгол өв уламжлалд суурилсан соёлын зөв хандлага төлөвшиж, өв соёлоо тээгч, хадгалан хамгаалдаг иргэдийн тоо нэмэгдсэн байна.
- Хотын өнгө үзэмж, цэвэр цэмцгэр байдал иргэдийн ухамсартай холбогдож, сайжирсан байна.
- Монгол Улсын төрөөс боловсрол, соёл, спортын салбарт баримтлах бодлого, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр хэмжигдэхүйц түвшинд үр дүнтэй биелэсэн байна.

Найм. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016 он	Зорилтот түвшин 2020 он	Хэрэгжүүлэх байгууллага
Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлт					
1	Хотын иргэний эрх, үүргийн талаарх ойлголт мэдлэг олгох чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулсан цэцэрлэг, сургууль	тоо/жил	-	81	НХХ, БХ ЕБС, СӨББ
2	Хотын иргэн, хотын соёлын агуулга тусгагдсан сургалтын хөтөлбөр	тоо	-	3	НХХ, БХ ЕБС

3	Хүүхэд, багачуудад зориулсан урлаг, спорт, соёлын арга хэмжээний хамрагдалт	төрөл/тоо	60/10000	75/15000	НХХ, БХ БТСХ
Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт					
4	Соёлын солилцоо, гадаад хамтын ажиллагаа	тоо	3	6	НХХ, СТ, БХ, ГБХЗХХ
5	Соёлын биет бус өвийг өвлөн эзэмшсэн билиг авьяастан	тоо	-	30	НХХ, СТ
6	Соёлын биет бус өвийг таниулан сурталчилсан ажил	тоо	3	10	НХХ, СТ
Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт					
7	Эх хэл, бичиг соёлоо сурталчилсан, номтой нөхөрлөх чиглэлээр хүүхэд залуучуудын дунд зохион байгуулсан аян	тоо/жил	10	20	НХХ, БХ, СТ ГБХЗХХ Хороод
8	Хүүхэд залуучууд, хотын иргэнд зориулсан номын фондын баяжилт	тоо	6000	10000	НХХ, ХНӨ, ЕБС-иуд, хороод
9	Угийн бичиг хөтөлж хэвшсэн өрх	тоо	5000	15000	ГБХЗХХ СТ, Хороод
Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт					
10	Соёлыг үнэлэх шалгуурын дагуу зохион байгуулагдсан үйл ажиллагаанд оролцсон айл өрх, аж ахуй нэгж	тоо/жил	-	200	НХХ ГБХЗХХ СТ
11	Соёлтой иргэн, өрх, байгууллагад хэвшүүлэх дадлыг боловсруулан, шат дараалсан сургалт, сурталчилгаа	тоо	10	20	НХХ ГХХ СТ
Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт					
12	Урлаг, спорт, соёлын уралдаан тэмцээн болон сайн үйлсийн, ажлуудын төрөл, оролцогчид	төрөл/тоо	60/10000	75/15000	НХХ БХ СТ
13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмэшүүлэх, төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	тоо/жил	3	5	НХХ ГБХЗХХ БТСХ, СТ
14	Бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулсан байдал	тоо	80	судалгаанд суурилан зохион байгуулах	НХХ ИБТ Хороод



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

"Хамтдаа хөгжье" хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Иргэдийн оролцоотой орон нутгийн сайн засаглалыг бэхжүүлэх, хөдөлмөрлөх хүсэл сонирхолтой, ажилтай орлоготой иргэдтэй, эрүүл аюулгүй, нээлттэй хүртээмжтэй ажлын байр, ажиллах таатай орчин нөхцөл бүрдсэн, иргэн бүрийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаатай дүүрэг болох зорилго бүхий "Хамтдаа хөгжье" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100087

0:12017: Togtool

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралт



“ХАМТДАА ХӨГЖЬЕ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 батлах тухай” 19 дүгээр тогтоолын 2.2 буюу нийгмийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн зарчимд “Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах” заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3 дугаар зүйлд “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна” гэж тусгагдсан.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан байхгүй, хороод дээр хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд иргэдийн оролцоог хангах, иргэд хамтран бүлэг зохион байгуулалтанд орж хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажил, мэдээлэл дутмаг байсаар байна. Тиймээс хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажилд зуучлагч, ажил олгогчдын эргэх холбоог сайжруулах шаардлага нийгмээс урган гарч байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 71 дүгээр тогтоолоор “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг батлуулан, хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд дүүргийн 14046 ажилгүй иргэдийг бүртгэснээс 57 хувь буюу 7435 иргэнийг ажилд зуучлан, 8888 иргэнийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулсан байна. Мөн хөтөлбөр хэрэгжсэн 2 жилийн хугацаанд 461 иргэнд 614 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 218 иргэнд 1.040.910 мянган төгрөгийн жижиг зээл олгож, 348 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 384 сая төгрөгийн ажлын байрыг нэмэгдүүлэх буцалтгүй тусламж олгожээ.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2 дахь зорилтод “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн асуудлыг нэг зорилт болгон авч хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах нь ардчиллыг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах,

хөгжлийн бусад санаачлагуудыг амжилттай хэрэгжүүлэх түлхүүр гэдгийг өнөөдөр хүн бүр хүлээн зөвшөөрч байна. Гэсэн хэдий ч мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгааны дүнгээс харахад шийдвэр гарах үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй, энэ нь иргэдийн мэдээлэл муу байдагтай холбоотой байна.

"Хамтдаа хөгжье" дэд хөтөлбөрийн хоёр дахь үндсэн чиглэл нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал юм. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн 2017 оны 1 дүгээр сарын мэдээгээр ажил идэвхтэй хайж байгаа буюу ажилгүй 2389 иргэн бүртгүүлсэн байна. Нийт ажил хайж байгаа эмэгтэйчүүд 1194 буюу 49.9 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 22 буюу 0.9 хувь байна. Насны бүлгээр авч үзвэл нийт ажил хайж байгаа иргэдийн 227 буюу 9.5 хувь нь 15-24 насны, 1007 буюу 42.2 хувь нь 25-34 насны, 633 буюу 26.5 хувь нь 35-44 насны, 405 буюу 16.9 хувь нь 45-54 насны, 118 буюу 4.9 хувь нь 55 дээш насны хүмүүс байна.

Ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл 899 дээд, 149 тусгай дунд, 94 техник мэргэжлийн, 1191 бүрэн дунд, 40 суурь, 12 бага боловсролтой, боловсролгүй иргэн 4 байна гэсэн судалгаа гарчээ.

Ажил идэвхтэй хайж буй, ажил олоход хүндрэлтэй байгаа иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, 40-өөс дээш насны иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдийг дэмжих, иргэдийг хамтран нөхөрлөл, хоршоо байгуулан ажиллах, тэдний хийж бүтээсэн зүйлсийг сурталчлах, зах зээлийн эргэлтэд оруулах, хөгжих, сурч боловсрох, мэргэших зэрэг тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ иргэдийн оролцоотойгоор орон нутгийг хөгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд тэдэнтэй хамтран ажиллах, иргэд, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах зэрэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Иргэдийн оролцоотой орон нутгийн сайн засаглалыг бэхжүүлэх, хөдөлмөрлөх хүсэл сонирхолтой, ажилтай орлоготой иргэдтэй, эрүүл аюулгүй, нээлттэй хүртээмжтэй ажлын байр, ажиллах таатай орчин нөхцөл бүрдсэн, иргэн бүрийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаатай дүүрэг болоход хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд, хүрэх үр дүн

Зорилт 1

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар орон нутгийн сайн засаглалыг бэхжүүлэх

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах, шинээр батлагдан гарах баримт бичгүүдийн төслийг нээлттэй мэдээлдэг, сурталчилдаг, хэлэлцүүлдэг байх арга механизмыг хэрэгжүүлэх;

2. Дүүргийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр иргэдийг хангах, тэдэнтэй зөвлөлдөх, тайлагнах тогтмолжиж хэвшсэн бүтэц, удирдлагын арга барил, эрх зүйн босго шаардлагыг бүрдүүлэх;
3. Иргэдийн саналыг зайлшгүй авсан байх ёстой эсвэл өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулах асуудлуудын жагсаалтыг гаргаж, мөрдөх;
4. Шийдвэр гаргахад оролцож буй иргэдийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлуудыг тогтмолжуулах, сонирхлын бүлэг багаар ажиллуулах;

Хүрэх үр дүн:

- Төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан хөгжлийн санаачилгууд амжилттай хэрэгжсэн байна.

Зорилт 2

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд иргэдийн тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэн, иргэд, төрийн байгууллагын хоорондын уялдаа холбоог ханган, хамтран ажиллах

Зорилт 2-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Хороодын "Иргэний танхим"-аар дамжуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавжуулах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах олон нийтийг идэвхжүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах;
2. Хороодын "Иргэний танхим"-аар дамжуулан иргэдийн амжилттай эхлүүлж буй бизнес, хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийг олон нийтэд сурталчилж, иргэдийн хөдөлмөрлөх хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
3. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн мэдээллийг цахим хуудсанд байршуулах, "Хамтдаа хөгжье" сэтгүүл, сонины дугааруудад нийтэлж, дүүргийн иргэдэд тогтмол хүргэх ажлыг зохион байгуулах;
4. Гэр хорооллын айл өрхүүдийг нийтийг хамарсан ажлуудад татан оролцуулах, тэр дундаа орчны тохижилт, эрүүл аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ажилд бүлгийн зохион байгуулалтаар ажилуулах, шаардлагатай багаж хэрэгслээр нэгдсэн журмаар хангах, урамшуулал олгох механизмыг нэвтрүүлэх;

Хүрэх үр дүн

- Олон нийт болон, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаа тогтмолжиж, иргэдийн сонирхлын бүлгүүд үүснэ.
- Иргэдийн сонирхлын бүлгүүдийн санал санаачилгыг дэмжсэнээр иргэдийн хөдөлмөрлөх хүсэл сонирхол нэмэгдэж, амьдрах орчин сайжирна.
- Иргэдийн мэдээллийн урсгал, мэдээлэл хүлээн авах суваг нэмэгдэж, үйлдвэрлэл өсч, орлого нэмэгдэнэ.

Зорилт 3.

Иргэдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, ажил хөдөлмөрт зуучлах

Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

1. Ажилгүй, ажилд ороод тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа иргэдийн бүртгэл, тандалт судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгааныг арилгуулах талаар ажил зохион байгуулах;
2. Залуучууд, ажил идэвхтэй хайж байгаа мэргэжилгүй иргэд, хугацаат цэргийн албанаас халагдаж ирсэн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн ур чадварт сургах, тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах;
3. Ажил хайж байгаа оюутан залуучууд, цэргийн алба хаасан иргэдийг байнгын, цагийн, өдрийн, гэрээт цэргийн албанд зуучлан, ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудтай эргэх холбоотой ажиллах;
4. Дүүрэгт шинээр байгуулагдаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, нөхөрлөл, хоршоо, бүлэгт бий болсон ажлын байранд иргэдийг ажилд зуучлах, дүүрэгт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажилд иргэд, иргэдийн бүлгийн оролцоог хангах;

Хүрэх үр дүн

- Ажилгүй иргэдийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар нэгдсэн судалгааны баазтай болж, жил бүр шинэчлэн баяжуулж, ажилд ороод 6-аас доош сар ажлаад гарч буй иргэдээс авах тандалт судалгааг хагас жилд нэг удаа зорилтот иргэдийн 10%-аас доошгүй хувийг хамруулан, дүн шинжилгээ хийсэн байна.
- Жил бүр тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа болон ажил мэргэжилгүй 250-иас доошгүй иргэдийг мэргэжлийн чадвар олгох сургалт, түр болон давтан сургалтад хамруулсан байна.
- Ажил олгогч болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай жилд нэгээс доошгүй удаа /20-оос доошгүй ажил олгогч/ уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байна. Ажил олгогчидтой эргэх холбоотой ажилласнаар тогтвор суурьшилтай ажиллах иргэдийн тоо нэмэгдэнэ.

Зорилт 4.

Хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй боловч эдийн засгийн хувьд боломжгүй иргэдэд дэмжлэг үзүүлэх

Зорилт 4-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

1. Хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг ур чадвар олгох, төсөл бичих, орлого зарлагаа хянах, аж ахуй эрхлэх сургалтад хамруулж, зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах;
2. 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нөхөрлөл, хоршоо, бүлэг байгуулах, өрхийн үйлдвэрлэл эрхлэх, ахмад

- мэргэжилтний зөвлөх үйлчилгээг эрхлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, дэмжих ажлыг зохион байгуулах;
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хоршоо нөхөрлөл байгуулан хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн сонирхлын бүлгүүдийг хөгжүүлэн, санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;
 4. Өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжих хүрээнд зөөврийн ажлын байр бий болгох санаачилгыг эхлүүлэх;
 5. Иргэдийн өөрсдийн үүсгэл санаачлагаар бүтээлч ажил өрнүүлэх, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бүлгүүдийн дунд амьдрах орчноо сайжруулах чиглэлээр жижиг төслийн уралдаан зарлаж, үр дүнг нь тооцон ажиллах;

Хүрэх үр дүн

- Хувиараа хөдөлмөр эрхлэх, өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдэд сургалт, хэлэлцүүлгийг хороо бүрт 20-иос доошгүй хүнийг хамруулах ажлыг зохион байгуулснаар эрхэлж буй бизнес, үйлдвэрлэлээ хэвийн явуулж, өргөжүүлэх арга зүйд сурсан байна.
- 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр эмзэг бүлгийн иргэдийн орлого, ажлын байр нэмэгдэн, халамжлуулах биш хөдөлмөрлөх хүсэл эрмэлзлэлтэй болсон байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, төсөл хөтөлбөрийг иргэд олон нийтэд хүргэсэнээр иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээ буурч, хувиараа болон хамтран хөдөлмөрлөх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, амьдралаа дээшлүүлэх хүсэл эрмэлзэл нэмэгдсэн байна.

Зорилт 5.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Зорилт 5-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

1. Иргэдийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулан тохирох ажилд зуучлах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад нөлөөллийн ажил зохион байгуулж, хамтран ажиллах;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамтран хөдөлмөр эрхлэх, сонирхлын бүлгүүд байгуулах, хувиараа хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, тэднийг идэвхжүүлэх, сурталчлах ажлыг улирал бүр зохион байгуулах;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал санаачилгыг дэмжин сонирхлын бүлгүүдийн дунд ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр зээл тусламжинд хамруулах, жилд жижиг төслийн уралдаан зарлан шалгарсан 3-4 төслийг санхүүжүүлэх, үр дүнг тооцон ажиллах;

Хүрэх үр дүн

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулсан нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудыг тогтмол урамшуулдаг, тэднийг дэмждэг болсон байх бөгөөд төр, аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхжүүлэх үйл ажиллагаа хороо бүрт улирал тутам тогтмол зохион байгуулагдаж, хороо тус бүрт 3-5 хамтын бүлгүүд байгуулагдаж үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгуулсан сонирхлын бүлгүүдийг идэвхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх ажлуудыг хорооны Иргэний танхимуудаар дамжуулан зохион байгуулж жилд ажлын байрыг нэмэгдүүлэх 3-4 төслийг шалгаруулан хэрэгжүүлсэн байна.

Зорилт 6.

Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгож, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх санал санаачлага гаргасан аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих

Зорилт 6-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд

1. Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, үр бүтээлтэй ажилласан хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо, иргэнийг шалгаруулан шагнаж, урамшуулах, сурталчлах;
2. Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч, иргэдийг тогтвор суурьшилтай ажлын байраар ханган ажиллуулагч иргэн, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулан шагнаж, урамшуулах ажлыг зохион байгуулах;

Хүрэх үр дүн

- Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн, эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага, иргэнийг шалгаруулан шагнаж урамшуулснаар байгууллага, иргэдийн хөдөлмөрлөх нөхцөл сайжирсан байна.

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хугацаа

Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

- Хөтөлбөрийн хамрах хүрээ:
 - ✓ Тогтвортой суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа иргэд
 - ✓ Хувиараа болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхээр эхэлж байгаа иргэд
 - ✓ Ажил идэвхтэй хайж байгаа мэргэжилгүй иргэд
 - ✓ Ажил олгогч эзэд, аж ахуйн нэгж байгууллагууд
 - ✓ Мэргэжил олгогч сургалтын төвүүд
 - ✓ Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- Улс, нийслэл, орон нутгийн төсөв
- Үндэсний ба олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр

- Олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагын хандив, тусламж
- Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
- Санхүү, төрийн сангийн хэлтэс
- Нийгмийн хөгжлийн хэлтэс
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтэс
- Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
- Худалдан авах ажиллагааны алба
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Бизнес инкубатор төв
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс
- Ахмадын хороо
- Хороодын Засаг даргын Ажлын алба
- ОУ болон ТББ

"Хамтдаа хөгжье" хөтөлбөрийг удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг арга зүйгээр хангаж зохицуулах, хянаж, үнэлэх үүргийг Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс хүлээнэ.

Хороодын Засаг даргын ажлын алба, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд иргэдийн болон хамтрагч бүх талын төлөөлөл жигд, идэвхтэй оролцоно.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ

Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс хэрэгжилтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд жилд нэг удаа тайлагнана.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2016	Зорилтот түвшин 2020	Хэрэгжүүлэх байгууллага
Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлт					
1	Шийдвэр гаргах үйл явцад оролцсон иргэд	тоо/жилд	1000	5000	ТЗУХ ХБТХАХ
2	Иргэдээр хэлэлцүүлэн баталсан шинэ баримт бичиг	тоо/жилд	30	100	ТЗУХ ХБТХАХ
3	Иргэдийн саналыг авахаар тусгасан асуудал (жагсаалтад орсон)	тоо/жилд	10	50	ТЗУХ ХБТХАХ
Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт					
4	Хөрөнгө оруулалт, бүтээн	тоо/жилд	-	1000	ХХҮХ

	байгуулалтад оролцож, ажилласан иргэд				Хороод
5	Шинээр байгуулагдсан "Иргэдийн бүлэг"	тоо/хороо бүрт	54	100	ХХҮХ Хороод
6	Үйлдвэрлэгчдийн мэдээллийг байршуулсан, "Хамтдаа хөгжье" сэтгүүл, сонины дугаар	тоо	2	4	НХХ БИТ ХХҮХ
Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт					
7	Ажилгүй, ажилд ороод тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байгаа иргэдэд чиглэсэн ажил	тоо	-	16	ХХҮХ, Хороод
8	Ажилд зуучлагдсан иргэд	тоо	2214	10000	ХХҮХ Хороод
9	Оюутан залуучууд, цэргийн алба хаасан иргэдийг цагийн, өдрийн, ажил болон гэрээт цэргийн албанд зуучилсан байдал	тоо	107 /цэргээс халагдсан, залуучууд/	800	ХХҮХ, Хороод
10	Иргэд, иргэдийн бүлгийг оролцуулсан хөрөнгө оруулалтын ажил	тоо	10 ажлыг 8 бүлэг	20 ажлыг 16 бүлэг	НХХ, СТСХ, Хороод
Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт					
11	Аж ахуй, бизнес эрхлэх сургалтад хамрагдаж, зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангасан иргэд	тоо/жил	3020	12800	ХХҮХ
12	40-өөс дээш насны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, ахмад настны тоо	тоо/жил	359	1600	ХХҮХ
13	Мэргэжлийн чадамж олгох сургалтад хамрагдаж ажилд зуучлагдсан залуучууд	тоо/жил	-	1200	ХХҮХ Хороод
14	Төслийн уралдаанд ирүүлсэн төсөл, хөтөлбөрүүд	тоо/жил	-	12-20	НХХ, ХБТХАХ, СТСХ, ХХҮХ, Хороод
Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт					
15	Сургалт, дэмжлэг, зээл, хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд	тоо/жил	299 хүн сургалтад 212 ХБИ санхүүгийн дэмжлэгт	1500 хүн сургалтад 1000 зээл, дэмжлэг, төсөлд	НХХ ХХҮХ Хороод ХБИХолбоо
16	Хороод дээр байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй	тоо	2 /1-19	Хороо тус бүрт 3-5	НХХ Хороод

	иргэдийн бүлэг"-үүд		хорооны хэмжээнд/	бүлэг	ХБИХолбоо
17	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал санаачилгаар дэмжигдэж, санхүүжигдсэн төсөл	тоо	2	10	НХХ,СТСХ, ХБТХАХ, Хороод, ХБИХолбоо
Зорилт 6-ын шалгуур үзүүлэлт					
15	Шинийг санаачлан үр бүтээлтэй ажиллаж буй аж ахуйн нэгжийн шалгаруулалтад оролцох аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	тоо/ жил	-	40	НХХ ХХҮХ
16	Эрүүл аюулгүй ажлын байрны шалгаруулалтад оролцох аж ахуй нэгж	тоо/жил	6	40	НХХ ХХҮХ

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

Нийгмийн амьдралд:

- Хөтөлбөр хэрэгжих хугацаанд дүүргийн хэмжээнд 20000 орчим иргэдийг мэргэжлийн чадамж олгох сургалтад хамруулан, 10000-аас доошгүй иргэдийг ажилд зуучлан, иргэд тогтмол орлоготой болж амьжиргааны түвшин нь дээшилсэн байна.
- Ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой залуучуудын идэвх нэмэгдэж, амьдрах орчин, амьдралын чанарт өөрчлөлт гарсан байна.

Эдийн засгийн хувьд:

- Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулсан аж ахуйн нэгж, байгууллагууд бий болж, тогтвортой ажлын байр нэмэгдэнэ.
- Хувиараа аж ахуй эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид, иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн бүтээмж сайжирч, иргэдийн орлого нэмэгдэнэ.